

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 172

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА,
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	4
172.1 Зорилго.....	4
172.3 Тодорхойлолт	4
172.5 Гэрчилгээнд тавигдах шаардлага	5
172.7 Өргөдөл гаргах.....	5
172.9 Гэрчилгээ олгох.....	5
172.11 Гэрчилгээгээр олгогдох эрх.....	6
172.13 Гэрчилгээний хугацаа	6
172.15 Гэрчилгээг шинэчлэх	6
172.17. Нөөц.....	7
Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	7
172.51. Ажилтанд тавигдах шаардлага.....	7
172.53 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний сургалт, дадлага	7
172.55. Ядралаас сэргийлэх (нөөц)	8
172.57. Байгууламжид тавигдах шаардлага.....	10
172.59. Үйлчилгээг тогтоох ба шилжүүлэх	10
172.61. Ээлжийн удирдлага.....	11
172.63. Баримт бичгүүд.....	11
172.65. Нөөц төлөвлөгөө	11
172.67. Харилцан ажиллагааны зохицуулалт	13
172.69. Тоног төхөөрөмжийн ажиллагааны илтгэл.....	13
172.71. Ерөнхий мэдээлэл	14
172.73. Цаг агаарын мэдээ ба илтгэл.....	14
172.75. Бүсийн ба Ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ.....	15
172.77. Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ	17
172.79. Тусгай зориулалтын агаарын зай	18
172.81. Удирдлагын хариуцлага.....	19
172.83. Үйлчилгээний эрэмбэ.....	20
172.85. Нислэгийн үрсгал зохицуулалт.....	20
172.87. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл	20
172.89. Нислэгийн цуваа	22
172.91. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрлөөс гажих	22
172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ	24
172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ	25
172.97. Аюулын түгшүүрийн мэдээллийн үйлчилгээ	25
172.99. Нислэгийн төлөвлөгөө	25
172.101. Цаг.....	26
172.103. Даралтын тохируулгын журам	27
172.105. Радио ба телефон холбооны журам.....	27
172.107. Нислэгийн хөдөлгөөний ажиглалтын үйлчилгээ	27
172.109. Агаарын хөлгийн нислэгийн онцгой тохиолдол ба хэвийн бус нөхцөл.....	27
172.111. Осол ба ноцтой зөрчлийн дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа.....	29
172.113. Зөрчил	30

172.115. Бичлэг	30
172.117. Ээлжийн ба ажлын байрны бүртгэл	30
172.119. Аюулгүй байдал, хамгаалалт	32
172.121. Үйлчилгээний саатал	
172.123. Дотоод чанар баталгаажуулалт	
172.125. Байгууллагын үйл ажиллагааны заавар	

В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА..... 33

172.151. continued compliance	33
172.151.А Шилжилтийн зохицуулалт.....	Error! Bookmark not defined.
172.153. Үйл ажиллагааны журам	33
172.155. Түршилтын зөвшөөрөл	34
172.157. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл олгохоос татгалзах	34
172.159. Ил харааны нислэгийг хориглох.....	34
172.161. Гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулалтын өөрчлөлт	34
172.163. Үйлчилгээг цуцлах ба шилжүүлэх	35
172.165. Аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр	

Г БҮЛЭГ. НИСЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ БУС ҮЙЛЧИЛГЭЭ

172.201. Ерөнхий зүйл	
172.203. Шаардлага	
172.205. Хүсэлт гаргах	
172.207. Гэрчилгээ олгох	
172.209. Үйлчилгээний нөхцөл	

Д БҮЛЭГ. ЗАЙЧЛАЛЫН МИНИМУМ

172.251. Босоо зайчлал	
172.253. Хосолсон ил харааны зайчлал	
172.255. Аэродромын бүсээс гаднах ил харааны зайчлал	
172.257. Хугацаат тууш зайчлал	
172.259. Зайн хэмжээт тууш зайчлал	
172.261. Хажуугийн зайчлал	
172.263. Хэрэглэлээр ойртолт үйлдэх агаарын хөлгүүд хоорондын зайчлал	
172.265. Багасгасан радар зайчлал	
172.267. Танигдаагүй хяналттай агаарын хөлгөөс зайчлах радар зайчлал	
172.269. Хүлээх нислэг үйлдэж байгаа агаарын хөлгөөс зайчлах радар зайчлал	
172.271. Үзүүлбэр нислэг	
172.273. ХБЗ-ны багасгасан зайчлал - Ерөнхий	
172.275. ХБЗ-ны багасгасан зайчлал - Хөөрөлт хооронд	
172.277. ХБЗ-ны багасгасан зайчлал - Хөөрөлт ба буулт	
172.279. ХБЗ-ны багасгасан зайчлал - Буулт хооронд	
172.281. Параллель зурвас дахь үйл ажиллагаа	
172.283. Түлш юүлж байгаа агаарын хөлгөөс зайчлах	
172.285. Цэргийн агаарын хөлгөөс зайчлах	
172.287. ХНД-ээр дараалан хөөрөх агаарын хөлгүүдийн зайчлал	
172.289. Нисдэг тэрэг ба хөдөлгүүргүй агаарын хөлөг	
172.291. Арын хуйлралын зайчлал	
172.293. Үйл ажиллагаа явагдаж байгаа тусгай зориулалтын агаарын зайгаас зайчлах	
172.295. (Revoked)	

Е БҮЛЭГ. СТАНДАРТ ХЭВШМЭЛ ХЭЛЛЭГ

172.351. Үйлчлэл

172.353. Нислэгийн удирдагч-нисэгч хоорондын хэвшмэл хэллэг

172.355. Нислэгийн хөдөлгөөний харилцан зохицуулалтын хэвшмэл хэллэг

Ж БҮЛЭГ. РАДАРЫН ЖУРАМ

172.401. Хоёрдогч радарын нэвтрүүлэгчийн С горимын өндрийн мэдээллийг баталгаажуулах

172.403. Хурдны хяналт

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын
2010 оны 03 дугаар сарын 22 -ны өдрийн
75 тоот тушаалын 2 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 172

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

172.1 Зорилго

(a) Энэхүү дүрмээр:

- (1) Улаанбаатар Нислэгийн мэдээллийн районд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ хангагдах нэгж агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэх байгууллагыг гэрчилгээжүүлэх, түүний үйл ажиллагааны шаардлагыг тодорхойлох; ба
- (2) Уг байгууллагын эрхлэх нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үйл ажиллагааны ба техникийн стандартыг тогтооно.

(b) А, В, С бүлгүүд нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тодорхойлолтын (1)-ээс (6) заалтуудад тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд хамаарна.

(c) D бүлэг нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тодорхойлолтын (7)-д заагдсан үйлчилгээнд хамаарна.

172.3 Тодорхойлолт

Ажлын байр гэж тухайн хариуцлагын бүсэд нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ явуулах ажлын байрыг;

Аюултай ойртолтоос зайлах зөвлөмж гэж нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт, түүнийг өөр агаарын хөлөгтэй мөргөлдөхөөс сэргийлэх зорилгоор нислэгийн удирдагчаас өгөх зөвлөмжийг;

Doc4444 гэж Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас боловсруулан гаргасан Агаарын навигацийн үйлчилгээний зааврыг;

Doc7030 гэж Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас боловсруулан гаргасан Ойрхи Дорнод/Ази-Номхон далайн бүсэд мөрдөгдөх Бүсийн хавсралт журмыг;

Ил харааны нислэгийн онцгой журмаар үйлдэх нислэг гэж нислэгийн хөдөлгөөний удирдлагын район, бүсийн цаг агаарын байдал ил харааны нислэг үйлдэх нөхцөлөөс доогуур төвшинд орсон үед нислэгийн удирдагчаас өгсөн зөвшөөрлийн дагуу нислэгийг онцгой журмаар үргэлжлүүлэхийг;

Нислэгийн төлөвлөгөө гэж нисэх баг буюу түүнийг төлөөлөх этгээдээс нислэгийн хөдөлгөөний үйлчилгээгээр хангуулах зорилгоор нислэг эхлэхийн өмнө Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад ирүүлсэн, аливаа өөрчлөлт ороогүй үндсэн төлөвлөгөөг;

Нислэгийн хөдөлгөөн гэж тухайн хариуцлагын бүсэд байгаа агаарын хөлгүүдийн бүх төрлийн шилжилт хөдөлгөөний цогц үйл ажиллагааг;

Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл гэж нислэгийн удирдагчаас, нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт, түүний ойролцоо нислэг үйлдэж буй агаарын хөлгийн талаар өгөх мэдээллийг;

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний мэдээ гэж ICAO-гийн Doc4444-т заасан онцгой тохиолдлын мэдээ, нислэгийн хөдөлгөөний ба нислэгийн хөдөлгөөний удирдлагын мэдээ болон нислэгийн мэдээг;

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрээ гэж харилцан ажиллагааг зохицуулах зорилгоор нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний салбаруудын хооронд байгуулсан гэрээг;

Нэгж агаарын зай гэж ИНД-71-ын дагуу тогтоогдсон удирдлагын бүс, нислэгийн мэдээллийн бүсийг;

Хариуцлагын бүс гэж нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, түүний салбар, нэгжийн хариуцсан агаарын зайг (аэродромын бүсийн хувьд маневрлах талбайг оролцуулна);

Үйл ажиллагааны журам гэж Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх үндсэн журам буюу журмуудын бүрдлийг;

Үйл ажиллагааны заавар гэж Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагчийн эрхлэх үйлчилгээ, түүний төрөл, бүтэц зохион байгуулалт, ажлын байр, боловсон хүчний хангалт, мөрдөх журам, заавар зэрэг үйл ажиллагаагаа зохих төвшинд явуулахад шаардагдах нөхцөлийг тодорхойлсон баримт бичгийг.

172.5 Гэрчилгээний шаардлага

Энэ дүрмийн дагуу гэрчилгээжиж, гэрчилгээний дагуу буюу гэрчилгээнд заагдсан эрх олгогдсоноос бусад этгээд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэхгүй.

172.7 Өргөдөл гаргах

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь:

(1) Доорх мэдээллийг шаардсан ИНЕГ0172/1 өргөдлийн маягтыг бөглөнө:

- (i) өргөдөл гаргагчийн нэр, Монгол Улс дахь албан ёсны хаяг;
- (ii) эрхлэх үйлчилгээ, эсхүл үйлчилгээнүүдийн төрөл;
- (iii) үйлчилгээ эрхлэх аэродром, агаарын зайн байршил, нэр;
- (iv) ИНЕГ-ын даргаас шаардаж маягтад тусгагдсан, өргөдөл гаргагч ба эрхлэх үйлчилгээтэй холбоотой шаардлагатай бусад мэдээлэл.

(2) бүрэн бөглөсөн өргөдлийн маягтыг ИНЕГ-ын даргад дараах баримт бичгийн хамт ирүүлнэ:

- (i) энэхүү дүрмийн 172.125-д заасан Үйл ажиллагааны заавар;
- (ii) хуульд заасан дүрмээр тогтоосон өргөдлийн төлбөрийн баримт.

172.9 Гэрчилгээ олгох

(a) (b)-д заасан НХҮБ-ын гэрчилгээг ИНЕГ -ын дарга нь дараах нөхцөлд олгоно:

(1) өргөдөл гаргагч энэ дүрмийн Б бүлэгт заасан шаардлагыг хангасан;

(2) өргөдөл гаргагч, түүний энэ дүрмийн 172.51-д заасан удирдах албан тушаалтан ба ажилтнууд нь зөв, тохирох хүн байх;

(3) гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх.

(b) ИНЕГ-ын дарга нь нисэхийн аюулгүй ажиллагааг алдагдуулахгүй байх зорилгоор өгөгдсөн хугацаанд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний зөвхөн нэг гэрчилгээ олгохыг бататгана.

172.11 Гэрчилгээгээр олгогдох эрх

(a) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрчилгээ нь доорх үйлчилгээнүүдийн алийг эрхлэх, уг үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой ямар сургалт, үнэлгээ шаардагдах, гэрчилгээ эзэмшигч ямар үйлчилгээ эрхлэх эрхтэй болохыг заана:

- (1) бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлага;
- (2) ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлага;
- (3) аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) аюулын түгшүүрийн мэдээллийн үйлчилгээ;
- (7) D бүлэгт заасан бусад үйлчилгээ.

(b) НХҮБ-ын гэрчилгээнд дараах зүйлсийг тусгасан байна:

- (1) үйлчилгээ эрхлэх аэродром, эсхүл агаарын зай;
- (2) ИНЕГ-ын даргаас шаардлагатай гэж үзэж шаардсан бусад нөхцөлүүд.

172.13 Гэрчилгээний хугацаа

(a) НХҮ-ний гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгох буюу сунгана.

(b) НХҮБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл ИНЕГ-ын дарга гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн буюу цуцалснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.

(c) Гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээг ИНЕГ-ын даргад хураалгана.

(d) Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээний үйлчлэлийг сэргээх тухай асуудлаар ИНЕГ-ын даргад хандана.

172.15 Гэрчилгээний хугацааг сунгах

(a) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах өргөдлийг ИНЕГ0172/2 маягтын дагуу гаргана.

(d) Өргөдлийг гэрчилгээнд заагдсан шинэчлэх хугацаанаас, эсхүл уг хугацааг тогтоогоогүй тохиолдолд гэрчилгээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

172.17. Нөөц**В БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА****172.51. Боловсон хүчинд тавигдах шаардлага**

- (a) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:
- (1) байгууллагын үйл ажиллагааны зааварт заагдсан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ нь дараах нөхцөлийг хангаж байгааг бататгах Гүйцэтгэх захирал:
 - (i) үйл ажиллагаа нь санхүүжиж байх;
 - (ii) үйл ажиллагаа нь энэ дүрмийн шаардлагын дагуу явагдаж байх;
 - (2) байгууллагын үйл ажиллагаа энэ дүрмийн шаардлагын хүрээнд явагдаж байгааг бататгах, хяналт тавих, үүрэг хариуцлага бүхий удирдах албан тушаалтан буюу тушаалтнууд. Томилогдсон уг албан тушаалтан буюу тушаалтнууд нь байгууллагын удирдлагад шууд захирагдаж илтгэдэг байна;
 - (3) байгууллагын Үйл ажиллагааны заавар, эрхлэх үйлчилгээний жагсаалтад тусгагдсан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, дотоод сургалтыг гардан явуулах мэргэжлийн ажилтнууд.
- (b) Өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:
- (1) байгууллагын үйл ажиллагааны зааварт тусгагдсан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ ба уг үйлчилгээний сургалт дадлага, үнэлгээ шинжилгээг гүйцэтгэх эрх олгогдсон ажилтны үр чадварыг бататгах;
 - (2) эрх олгогдсон ажилтанд олгогдсон эрхийг нь баталгаажуулсан баримтыг бичгэн хэлбэрээр гардуулсан байх;
 - (3) эрх олгогдсон ажилтан нь ИНД-65 дүрмийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр үнэмлэх зэрэглэлтэй байх;
 - (4) боломжтой бол эрх олгогдсон ажилтан нь зөвхөн хамгийн сүүлийн үеийн ба хүчин төгөлдөр холбогдох мэдээлэлтэй бол зэрэглэлд заагдсан эрхийг хэрэгжүүлдэг байх
 - (5) зэрэглэл бүхий нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үнэмлэх эзэмшигчийн хувьд ИНД-65 дүрмээр шаардсан дадлага түршлагажсан байх шаардлагыг хангасан байх;
 - (6) боломжтой бол нислэгийн удирдагч нь дараах тохиолдолд олгогдсон эрхээ хэрэгжүүлдэггүй байх:
 - (i) эрүүл мэндийн гэрчилгээний шаардлагыг хангахгүй байх;
 - (ii) аливаа өвчлөл нь олгогдсон эрхээ аюулгүй хэрэгжүүлэх нөхцөлийг хангахгүй байх.

172.53 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний сургалт, дадлага

- (a) Өргөдөл гаргагч нь дараах ажилтнуудыг сургаж, дадлагажуулах, үнэлэх журам, хөтөлбөртэй байна:

- (1) нислэгийн удирдагч;
 - (2) нислэгийн үйлчилгээний оператор;
 - (3) HF үелзлэлийн нисэхийн холбооны үйлчилгээнд шууд оролцогч ажилтан
 - (4) дараах ажилтнуудад туслах үрэг бүхий ажилтан:
 - (i) зэрэглэл бүхий нислэгийн удирдагч; ба
 - (ii) зэрэглэл бүхий нислэгийн үйлчилгээний оператор.
- (b) Өргөдөл гаргагч нь ажилтныг ажлын орчинд сургаж дадлагажуулах этгээд нь ИНД-65 дүрмийн дагуу олгогдсон багшлах хүчин төгөлдөр эрхтэй байх журмыг тогтоосон байна.
- (c) Өргөдөл гаргагч нь ажилтныг үнэмлэх, эсхүл зэрэглэл авах, баталгаажуулахад үнэлэх шалгах этгээд нь ИНД-65 дүрмийн дагуу олгогдсон багшлах эсхүл шалгах хүчин төгөлдөр эрхтэй байх журамтай байна.

172.55. Ядралаас сэргийлэх (нөөц)

172.57. Байгууламжид тавигдах шаардлага

- (a) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь байгууллагын үйл ажиллагааны зааварт тусгагдсан эрхлэх үйлчилгээний жагсаалтыг харгалзан дараах ажлын байрыг бэлтгэсэн байна:
- (1) аэродромын удирдлагын цамхаг;
 - (2) ойртолтын удирдлагын байр;
 - (3) бүсийн удирдлагын төв;
 - (4) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр;
 - (5) нислэгийн мэдээллийн үйлчилгээний төв;
 - (6) сургалт дадлага, шалгалт гүйцэтгэхэд зориулагдсан танхим, байгууламж.
- (b) (h)-д зааснаас бусад тохиолдолд аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагчийн аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхаг, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр, түүний дотор түр цамхаг болон байр нь дараах шаардлагыг хангасан байна:
- (1) барилгын зохиомж, байршлын хувьд:
 - (i) аэродромын нислэгийн хөдөлгөөнийг хянах боломжит орчны хамгийн их алсын барааны харагдацтай;
 - (ii) гэрлийн гялбалт, нөлөөллөөс хамгаалагдсан;
 - (iii) гаднах дуу чимээг намсгагч, түсгаарлагчтай байна.

- (2) энэ зүйлийн (b)-гийн (1)-д заасан шаардлагад үл нийцэх сөрөг нөлөөллөөс хамгаалагдсан байна;
- (3) нислэгийн хөдөлгөөнд зөвхөн нэг ажилтан байнгын хяналт тавих зориулалттай ажлын байрны хувьд:
- (i) үүрэгт ажлаасаа аль болох богино хугацаагаар хөндийрөх, ажлын чадварыг бууруулахгүй байлгах шаардлагаар ариун цэврийн өрөөтэй;
 - (ii) ил хараагаар тогтмол хяналт тавих зориулалттай тасалгаа нь хүнс, ундааны зүйлсийг хадгалах, бэлтгэх төхөөрөмжөөр тоноглогдсон;
- (4) дараах зүйлстэй харилцах хоёр талын дуун холбоотой байх:
- (i) хариуцлагын бүсэд буюу түүнд хил залгаа зэргэлдээ орших агаарын хөлөг;
 - (ii) маневрлах талбай эсхүл түүнтэй зэргэлдээ байгаа агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл, хүн;
- (5) НХҮ-нд зайлшгүй шаардлагатай дараах тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна:
- (i) төлөвлөгдсөн болон гүйцэтгэгдэж буй аэродромын нислэгийн хөдөлгөөний явц, хөдөлгөөний шилжилт, түүний хавсралт мэдээллийг агаарын хөлөг тус бүрээр үзүүлэх дэлгэц буюу дээрх зорилгоор ашиглагдах систем;
 - (ii) цахилгаан эрчим хүчний хангалт;
 - (iii) холбогдох, хүчин төгөлдөр газрын зураг, нислэгийн зураг, бүдүүвч;
 - (iv) дуран;
 - (v) цаг;
 - (vi) бүртгэл хадгалах систем;
 - (vii) гаднах агаарын температур заах хэмжүүр;
 - (viii) QNH даралтын хэмжүүр;
 - (ix) улаан, ногоон, цагаан өнгийн дохионы гэрэл;
 - (x) телефон утсан холбоо;
 - (xi) ойртолтын ба суултын системийн ажиллагаа илтгэх хэрэгсэл;
 - (xii) алсын барааны харагдац, үүлний доод суурийн өндрийг тодорхойлох хэрэгсэл;
 - (xiii) дуун, эсхүл ашиглагддаг тохиолдолд тоон өгөгдлийн бичлэгийн төхөөрөмж;
 - (xiv) салхины чиглэл, хурд заах хэрэгсэл;
 - (xv) ослын дуут дохиолол;
 - (xvi) AFTN сүлжээ (НХҮ-ний гэрээнд заасан тохиолдолд нислэгийн мэдээлэл солилцох нөөц суваг);
 - (xvii) шаардлагатай тохиолдолд аэродромын гэрэлтүүлгийн системийн удирдлагын самбар.
- (6) ил хараагаар хяналт тавих байр нь аэродромын төвшинг тодорхойлох зорилгоор анеройд бүхий даралт хэмжүүр, эсхүл барометрийн өндрийн хэрэглэлийн аль нэг нь байх, бие биенээсээ хамааралгүй өндрийн даралтын тохируулгын хоёр хэрэгсэлтэй байна.
- (c) Өргөдөл гаргагчийн бүсийн удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төв, ойртолтын удирдлагын байрууд дараах шаардлагыг хангасан байна:
- (1) өргөдөл гаргагчийн хариуцлагын агаарын зайд болон түүний зэргэлдээ нисч байгаа агаарын хөлөгтэй холбоо барих дараах тоноглолтой байх:
 - (i) боломжит хамгийн их бүрхэлт бүхий хоёр талын дуун радио-холбоотой;

(ii) ашиглагддаг бол өгөгдлийн холбоотой.

(2) НХҮ-нд зайлшгүй шаардлагатай дараах тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна:

- (i) тухайн хариуцлагын бүсэд нислэг үйлдэхээр төлөвлөгдсөн болон гүйцэтгэгдэж буй нислэгийн хөдөлгөөний явц, хөдөлгөөний шилжилт, түүний хавсралт мэдээллийг агаарын хөлөг тус бүрээр үзүүлэх дэлгэц буюу дээрх зорилгоор ашиглагдах систем;
- (ii) цахилгаан эрчим хүчний хангалт;
- (iii) холбогдох газрын зураг, нислэгийн зураг, бүдүүвч;
- (iv) цаг;
- (v) бүртгэл хадгалах систем;
- (vi) газрын навигаци, ойртолтын ба суултын систем, хэрэгслийн ажиллагаа, ашиглалтын байдлыг илтгэх монитор;
- (vii) телефон утсан холбоо;
- (viii) дуун бичлэгийн төхөөрөмж (ашигладаг бол тоон өгөгдлийн бичлэгийн төхөөрөмж);
- (ix) AFTN сүлжээ;
- (x) Ойртолтын удирдлагын байрны хувьд тухайн аэродромын ойртолтын ба ойртолтын радар удирдлагын ажлын байранд суултын систем (ILS)-ын ажиллагааг илтгэх монитор;
- (xi) Ойртолтын төгсгөлийн хэсэгт нисч байгаа, эсхүл бууж хөөрч байгаа агаарын хөлгийг Ойртолтын удирдлагаар хангадаг ажлын байрны хувьд аэродромын удирдлагын цамхагт ашиглагдаж буй системтэй ижил эх үүсвэр бүхий салхины чиглэл, хурд заах хэрэгсэл.

(d) Өргөдөл гаргагч нь, энэ зүйлийн (b), (c) хэсэгт заасан тоног төхөөрөмж, хэрэгслүүд нь ИНД-171-ийн шаардлагыг биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх журмыг тогтоосон байна.

(c) Өргөдөл гаргагч нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдах аливаа ил хараагаар ажиглах дэлгэц нь холбогдох мэдээллийн ач холбогдолд анхаарч, хэрэглэхэд хялбар байхуйцаар суурилуулагдсан байх журмыг тогтоосон байна.

(e) Энэ зүйлийн (b) хэсгийн (4), (5); (c) хэсгийн (1)-д заасан тоног төхөөрөмжийн гэнэтийн саатал, татгалзал, ашиглалт ба хүчин чадлын төвшний бууралт, нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгах зорилгоор нөөц тоног төхөөрөмжтэй байна.

(f) Энэ зүйлийн (b) хэсгийн (5)-ын (xi), (c) хэсгийн (2)-ын (vi)-т заасан хэрэгслүүд нь дараах нөхцөлийг хангасан байна:

(1) ажиллагааны төвшин буурсныг илтгэх дуут дохиололтой байх;

(2) ажиллагааны байдлыг илтгэх индикатортой байх.

172.59. Үйлчилгээ тогтоох ба хариуцлага шилжүүлэх

(a) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь өргөдөлдөө дараах зүйлсийг хавсаргана:

1/ гэрчилгээ олгогдсоноос хойшхи эхний 12 сарын

172.61. Ээлжийн удирдлага

(a) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) дараах хугацаанд ээлж бүрийн өмнө болон дараа ээлжийн өмнө, ээлж солилцох үйл ажиллагаанд тохиромжтой хугацааг зарцуулах:
 - (i) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө;
 - (ii) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлж дуусаад.
- (2) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажлын байранд ээлж шилжүүлэхээс өмнө нислэгийн хөдөлгөөний явцтай танилцахад 5 минутаас багагүй хугацааг зарцуулдаг байх.

172.63. Баримт бичиг

(a) Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа тусгасан үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай журам, заавар, техникийн ашиглалтын заавар болон удирдлагын бусад баримт бичгийн хувийг бүрдүүлж хадгална.

(b) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a) хэсэгт заагдсан баримт бичгийг хадгалах, ашиглах журмыг дараах шаардлагыг хангахуйцаар тогтоосон байна:

- (1) баримт бичгийг түгээхээс өмнө эрх бүхий албан тушаалтан танилцаж зөвшөөрсөн байх;
- (2) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний хүчин төгөлдөр баримт бичгийг түүнийг мөрдөж ажиллах ажлын байр, ажилтнуудад хүргэж танилцуулсан байх;
- (3) хүчингүй болсон баримт бичгийг ажлын байрнаас тухай бүрт нь татан авсан байх;
- (4) архивт шилжүүлж байгаа баримт бичигт хүчингүй болгосон тухай тэмдэглэлийг хийж хадгалах;
- (5) баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг эрх бүхий этгээд хянаж, зөвшөөрсөн, бүртгэсэн байх;
- (6) өөрчлөлт оруулсан баримт бичгийн хүчин төгөлдөр хувийг хүчингүй болгосон хувиас ялгах зорилгоор түүнд тусгайлан тэмдэглэл үйлдсэн байх.

(c) Ажлын байранд тогтмол хадгалахаас бусад баримт бичиг, мэдээллийг цахим хуудсаар дамжуулан түгээж болох ба энэ тохиолдолд цахим хуудаст нэвтрэх эрх, зэрэглэлийг тогтооно.

(d) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a), (b) хэсэгт заасан үйл ажиллагааг хариуцах, хяналт тавих этгээдийг томилж, энэ талаар хэрэгжүүлэх үүргийг ажлын байрны тодорхойлолтод нь тусгасан байна.

172.65. Нөөц төлөвлөгөө

(a) Өргөдөл гаргагч нь нислэгийн аюулгүй, тасралтгүй, шуурхай ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй тоног төхөөрөмжийн болон нислэгийнхөөлгөөний үйлчилгээний үйл ажиллагааны саатал, доголдол, түр хугацааны татгалзлын болон тэдгээрийг дэмжих үйл ажиллагааны үед хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөтэй байна.

172.67. Харилцан ажиллагааны зохицуулалтад тавигдах шаардлага

(a) Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт тусгасан НХҮ-ний салбарууд болон дараах байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах журмыг тогтоосон байна:

- (1) ИНД-171-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн холбооны байгууллага;
 - (2) ИНД-173-ын дагуу гэрчилгээжсэн хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллага;
 - (3) ИНД-174-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн цаг уурын байгууллага;
 - (4) ИНД-175-ын дагуу гэрчилгээжсэн нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага;
 - (5) агаарын тээвэр эрхлэгч байгууллага;
 - (6) Монгол Улсын Зэвсэгт хүчин;
 - (7) Эрэн хайх авран туслах үйл ажиллагаа эрхэлсэн байгууллага;
 - (8) Хэрэв өргөдөлд заагдсан нэгж нь аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага ба аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх бол:
 - (i) аэродром эзэмшигч, эсхүл
 - (ii) аэродромын удирдлагын нэгж нь зогсоол дээрхи хөдөлгөөнийг хариуцдаггүй бол зогсоолын зохицуулалтын нэгж.
- (b) Өргөдөл гаргагч нь эрхлэх үйлчилгээнийхээ жагсаалтад тусгагдсан салбар болон өөрт харъяалагдахгүй дараах салбаруудын хооронд НХУ-ний гэрээ байгуулах журмыг тогтоосон байна:
- (1) хариуцлагын бүсүүд нь шууд хиллэж байгаа зэргэлдээ нэгжүүд;
 - (2) байнгын харилцан зохицуулалт хийх шаардлагатай бусад НХУБ-ын -салбарууд.
- (c) НХУ-ний гэрээнд дараах зүйлс туссан байх журамтай байна:
- (1) талуудын үр дүнтэй харилцан ажиллагааг зохицуулах журмыг тодорхой тусгасан байх;
 - (2) хүчин төгөлдөр байх;
 - (3) эрх бүхий удирдах албан тушаалтан баталж албажуулсан байх;
 - (4) байгууллагын үйл ажиллагааны ерөнхий журам, зааврын салшгүй хэсэг болж мөрдөгдөж байх.
- (d) Өргөдөл гаргагч нь, НХУ-ний салбар нэгжүүдийн хоорондын харилцаа холбооны хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангасан холбооны системтэй байх ба харилцаа холбооны журмыг тогтоосон байна.
- (e) Өргөдөл гаргагч нь НХУ-ний салбар, агаарын хөлөг ашиглагч болон нислэгийн цаг уурын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай нислэгийн хөдөлгөөний мэдээлэл солилцох зорилгоор дараах мэдээллийг түгээх, түүнийг хэрэгжүүлэх холбооны системтэй байна:
- (1) үндсэн ба нэмэлт өөрчлөлт орсон нислэгийн төлөвлөгөө;
 - (2) нислэгийн хөдөлгөөний явцын талаарх мэдээлэл.

(f) Өргөдөл гаргагч нь CAVOK хэллэгийг ашиглахаас бусад тохиолдолд ICAO-гийн Doc 4444-ийн (IX хэсэг -НХҮ-ний мэдээ)-т заасан журмаар НХҮ-ний мэдээг бэлтгэж, түгээдэг байна.

172.69. Тоног төхөөрөмжийн ажиллагааны илтгэл

(a) Өргөдөл гаргагч нь, тоног төхөөрөмжийн хангалт, үйлчилгээний горим, ашиглалтын байдалд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллээр нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ ашиглагчийг хангах журмыг тогтоосон байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлийг дэлгэрэнгүй тусгана:

- (1) үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхтгэлд тусгуулах зорилгоор ИНД-175-ын дагуу гэрчилгээжсэн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад өгөх;
- (2) тоног төхөөрөмж, үйлчилгээний горимын түр хугацааны өөрчлөлт зэрэг NOTAM мэдээгээр түгээгдэхээс бусад нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй саатал, өөрчлөлтийн талаарх мэдээллээр нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ ашиглагчийг шуурхай хангах.

172.71. Нислэгийн ерөнхий мэдээлэл

(a) Өргөдөл гаргагч нь хариуцаж байгаа бүс дэх, нислэгт сөргөөр нөлөөлөх доорхи мэдээллийг шуурхай хүлээн авах журмыг тогтоосон байна:

- (1) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил;
- (2) галт уулын дэлбэрэлт;
- (3) галт уулын үнст үүл;
- (4) агаарт цацагдах цацраг идэвхит материал болон хорт бодисын талаарх мэдээлэл.

(b) Өргөдөл гаргагч нь хариуцаж байгаа бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа нэгжүүдийг тэдгээрийн хариуцлагын бүсэд хамааралтай дараах нислэгийн ерөнхий мэдээллээр хангадаг байна:

- (1) ил харааны бус навигацийн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал;
- (2) хөөрөлт, буултад ашиглагдах ил харааны хэрэгслүүдийн ашиглалтын байдал;
- (3) газар дахь шилжилт хөдөлгөөний зохицуулалтад ашиглагдах ил харааны ба ил харааны бус хэрэгслийн ашиглалтын байдал.

(c) Дараах нэгжүүдээс НХҮ эрхлэхээр өргөдөл гаргагч нь уг нэгжүүд нь хөдөлгөөнт талбай дахь онцгой нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүлээн авах журамтай байна. Уг мэдээлэлд түр зуурын аюул, аэродромын холбогдох байгууламжийн ашиглалтын нөхцөл байдал, горим багтсан байна:

- (1) аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхаг
- (2) ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын байр;
- (3) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр.

172.73. Цаг агаарын мэдээ ба илтгэл

(a) Өргөдөл гаргагч нь, агаарын хөлөгт үзүүлэх нислэгийн мэдээллийн үйлчилгээнд цаг агаарын хүчин төгөлдөр мэдээлэл агуулагдахээр хангах тогтолцоог бүрдүүлэх ба уг тогтолцоо нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) цаг агаарын мэдээг ИНД-174-ийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн цаг уурын байгууллагаас авч, баталгаажуулсан байх;
- (2) цаг агаарын мэдээ нь ИНД-174-ын 174.3 ба 174.6 заасны дагуу, нисэхийн цаг агаарын үндсэн мэдээ хэлбэрээр бэлтгэгдсэн байх.

(b) Өргөдөл гаргагч нь түүний нэгжүүд үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг агаарын мэдээг НХУ-ний ажилтны үйл ажиллагаанд хамгийн багаар нөлөөлж тасалдуулахгүй хэлбэрээр хангагддаг байх тогтолцоотой байна.

(c) Өргөдөл гаргагч нь цаг агаарын үндсэн мэдээлэлд ашиглагдах тоног төхөөрөмж нь дараах шаардлагыг хангах журамтай байна:

- (1) хэмжилт нь тухайн хариуцлагын бүсийн цаг уурын байдлыг бүрэн тодорхойлохуйц байх;
- (2) хэд хэдэн салхины чиглэл, хурд хэмжигч, заагч, ХБЗ дээрхи алсын барааны харагдацыг илтгэх, агаарын температур, даралтыг заах хэмжүүр, хэмжих хэрэгслийн иж бүрдэл байх.

(d) Өргөдөл гаргагч нь, мэдээллийн хүүдас хэлбэрээр хүлээн авсан цаг агаарын мэдээг радио-холбоогоор түгээх үед ямар нэг алдаа гарах, буруу мэдээлэгдэхээс сэргийлэх, хяналт тавих журмыг тогтоосон байна.

172.75. Бүсийн ба ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлага

(a) Бүсийн ба ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлага эрхлэхээр өргөдөл гаргагч нь дараах үйл ажиллагааг зохицуулах журмыг тогтоосон байна:

- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэлд тулгуурлан агаарын хөлгүүд хоорондын байрлал, харьцааг тодорхойлох;
- (2) агаарын зайн ангилал, нислэгийн төрлөөс хамааран нислэгийн хөдөлгөөний аюулгүй, шуурхай урсгалыг хангах зорилго бүхий НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх;
- (3) НХУ-ний зэргэлдээх болон шаардлагатай бусад салбар, нэгжүүдтэй НХУ-ын зөвшөөрлийн харилцан зохицуулалт хийх;
- (4) НХУ-ын үйл ажиллагаанд шинжилгээ, дүгнэлт хийх зорилгоор зөвшөөрөл олгосон байдал, нислэгийн хөдөлгөөний явцын мэдээллийг хамтатгаж бэлтгэн үзүүлэх.

(b) Дор дурдсан нислэгүүд хооронд, энэ зүйлийн (d) болон энэ дүрмийн 172.91 зүйлд зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (a) хэсгийн (2)-т заасны дагуу, мөн энэ зүйлийн (c) хэсэгт заасныг баримтлан босоо ба хэвтээ, эсхүл хосолмол зайчлалыг хангах журмыг тогтоосон байна:

- (1) “А” ба “В” ангиллын агаарын зайд үйлдэгдэж буй бүх агаарын хөлөг;

- (2) “С” ба “D” ангиллын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
- (3) “С” ангиллын агаарын зайд ХНД ба Ил харааны нислэгийн дүрэм (ИХНД)-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
- (4) “В”, “С”, “D” ангиллын агаарын зайд ХНД ба ИХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
- (5) “В”, “С,” ”D” агаарын зайд, нислэгийн алсын барааны харагдаж 5 км-ээс бага тохиолдолд ИХНОД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
- (с) Энэ зүйлийн (b)-д заасан зайчлалыг нь дараах баримт бичгүүдэд заагдсан хязгаарлалт, шаардлагын дагуу мөрдөнө:
- (1) Энэ дүрмийн Д бүлэг;
- (2) Конвенцийн 11 дүгээр хавсралт
- (3) ИКАО-гийн Док 4444
- (4) ИКАО-гийн Док 7030.
- (d) “D” ба “E” ангиллын агаарын зайн хувьд ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт НХУ-аар хангагдсан бусад агаарын хөлгүүдтэй аюулгүй зайгаа өөрөө тодорхойлон хадгалах зөвшөөрөл, заавар олгосон тохиолдолд энэ зүйлийн (b) хэсгийн (2)-д заасан зайчлалыг баримтлах шаардлагагүй. Энэхүү зөвшөөрөл, зааврыг зөвхөн дараах нөхцөлд олгоно:
- (1) Нисэх баг бусад агаарын хөлгөөс аюулгүй зайгаа өөрөө ханган нисэх зөвшөөрөл хүссэн;
- (2) нислэгийг зөвхөн өдрийн цагт, ил хараагаар нислэг үйлдэх цаг агаарын нөхцөлд үйлдэж байгаа тохиолдолд;
- (3) бодит хяналтын системийн хангалтгүй үед;
- (4) зөвшөөрөл нь нислэгийн тухайлан заасан үе шатанд хүчин төгөлдөр байх;
- (5) зайчлалын энэхүү аргыг ашиглаж байгааг онцгой нислэгт тооцогдох бүх агаарын хөлөг зөвшөөрсөн байх;
- (6) зайчлалын уг аргыг ашиглаж байгаа талаар холбогдох бусад агаарын хөлөгт мэдээлсэн байх;
- (7) уг арга үйлчилж байгаа бүс дэх агаарын хөлгүүд радио-холбооны ижил давтамж дээр НХУ-ын нэгжтэй байнгын холбоотой байна.

172.77. Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага

- (a) Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага эрхлэхээр өргөдөл гаргагч нь дараах ажиллагааг зохицуулах журмыг тогтоосон байна:
- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэл ба ил харааны хяналтад тулгуурлан агаарын хөлгүүдийн хоорондын байрлал, харьцааг тодорхойлох;

- (2) дараах агаарын хөлгүүд өөр хоорондоо буюу газар дахь саадтай мөргөлдөхөөс сэргийлэх зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх:
- (i) аэродромын бүсэд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (ii) хөөрөлт, буулт үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (iii) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (iv) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлөг ба тээврийн хэрэгсэл, хүн
 - (v) маневрлах талбай дахь агаарын хөлөг ба саад.
- (3) нислэгийн хөдөлгөөний аюулгүй, шуурхай үрсгалыг хангах зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, заавар, зөвлөмж, мэдээлэл өгөх;
- (4) энэ дүрмийн 172.91 ба 172.295 зүйлд зааснаас бусад тохиолдолд, ХБЗ-ны орчмын ба агаарын хөлгийн дагалдах хуйлралаас сэргийлэх зайчлалыг дараах баримт бичгүүдэд заасан зайчлалын стандартын дагуу баримтлах:
- (i) Энэ дүрмийн Д бүлэг;
 - (ii) Конвенцийн 11 дүгээр хавсралт
 - (iii) ИКАО-гийн Док 4444
 - (iv) ИКАО-гийн Док 7030.
- (5) аюулд орсон буюу аюул тулгарсан агаарын хөлөгт яаралтай түслэмж үзүүлэх зорилготой тээврийн хэрэгсэл нь газрын бусад тээврийн хэрэгслээс давуу эрхтэй байх;
- (6) маневрлах талбайд зорчиж буй хүн, тээврийн хэрэгсэл, чирүүлж буй агаарын хөлөг ба хөөрөлт, буулт, явгалалт үйлдэж буй агаарын хөлөг хоорондоо мөргөлдөх аюулаас сэргийлэн тогтмол хяналт тавьж байх;
- (7) НХУ-ний бусад салбар, нэгжүүдтэй харилцан зохицуулалт хийгдэж байх;
- (8) НХУ-ыг гүйцэтгэж байгаа тухайн ажлын байранд нислэгийн хөдөлгөөний явц, өөрчлөлтийн мэдээллийг тасралтгүй илтгэн үзүүлэх.
- (b) Өргөдөл гаргагч нь, агаарын хөлөгтэй харьцах радио-холбоогүй үед (a)-гийн (2)-д заасан агаарын хөлөгт зөвшөөрөл, заавар, мэдээллийг ИНД-91.243-д заасан гэрлэн дохиолол ашиглан түүнд заасны дагуу олгох журамтай байна.
- (c) Өргөдөл гаргагч нь цаг агаар, эсхүл ойртолтын зэрэглэл зэргээс хамаарч дараах журмыг тогтоосон байна:
- (1) ILS-аар ойртолт хийж байгаа агаарын хөлөг нь ILS-д нөлөөл орсон талаар буюу магадлалын талаар мэдээлэгдсэн байх
 - (2) Агаарын хөлөг ILS-д орсон, эсхүл ILS-д бусад нөлөөлөл үгүй байх ёстой ойртолтын тодорхой цэгт хүрсэн үед ILS нь нөлөөллөөс сэргийлэгдсэн байх.
- (d) Өргөдөл гаргагч нь, энэ дүрмийн 172.85 зүйлд зааснаас бусад тохиолдолд дараах нислэгүүдийн хооронд босоо, хэвтээ болон хосломол зайчлалыг баримтлах журмыг тогтоосон байна:
- (1) ХНД ба ИХНОД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд хооронд;

(2) алсын барааны харагдац 5 км-ээс бага байгаа нөхцөлд ИХНОД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд хооронд.

(e) Өргөдөл гаргагч нь аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагад ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсийн зарим хэсгийг хариуцуулсан, эсхүл аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсийн зарим хэсгийг ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагад хариуцуулан нэгтгэсэн тохиолдолд тухайн бүсэд НХУ-аар хангагдаж байгаа агаарын хөлгүүд хооронд зайчлалыг баримтлах журмыг тогтоосон байна.

(f) Энэ зүйлийн (d), (e) хэсэгт заасан босоо, хэвтээ болон хосломол зайчлал нь дараах баримт бичгүүдэд заасан стандартын дагуу тогтоогдоно:

- (3) Энэ дүрмийн Д бүлэг;
- (4) Конвенцийн 11 дүгээр хавсралт
- (5) ИКАО-гийн Док 4444
- (6) ИКАО-гийн Док 7030.

172.79. Тусгай зориулалтын агаарын зай

Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 172.293-д заасан зайчлал хангагдах ёстой агаарын хөлгүүд ИНД-71 дүрмийн дагуу тогтоогдсон идэвхитэй тусгай зориулалтын агаарын зайгаас дараах тохиолдолоос бусад үед зайчлагдах журмыг тогтоосон байна:

- (1) Нисэх баг уг агаарын зайг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан;
- (2) Аюутай агаарын зай, эсхүл галт уулын идэвжилийн аюултай бүсийн хувьд, нисэх баг уг бүсэд нислэг үйлдэх тухайгаа илтгэсэн;
- (3) Аюултай бүсэд нислэг хийж байгаа агаарын хөлгийн нисэх баг ИХНД-ээр, эсхүл ил харааны баримжаа ашиглан ХНД-ээр нисч байгаагаа илтгэсэн, эсхүл мэдэгдсэн;
- (4) Нисэх баг уг агаарын зайгаас өөрөө зайчлалаа хадгалан нисэхээ илтгэсэн.

172.81. Хариуцлага

(a) НХУ эрхлэхээр өргөдөл гаргагч нь, НХУ-аар хангагдаж байгаа нислэгийг нэгж хугацаанд зөвхөн нэг салбар, нэгжийн удирдлагаар хангах журмыг тогтоосон байна.

(b) Өргөдөл гаргагч нь, тогтоосон нэгж агаарын зайн бүс, сектор дахь нислэгийн хөдөлгөөний удирдлагыг зөвхөн нэг байр хариуцан гүйцэтгэх журмыг тогтоосон байна. Агаарын хөлөг буюу бүлэг агаарын хөлгийн НХУ-ыг өөр ажлын байрны хариуцлагад нэгтгэхдээ зэргэлдээх ажлын байруудтай урьдчилсан харилцан зохицуулалт хийх журмыг мөрдөнө.

(c) Өргөдөл гаргагч нь агаарын хөлгийн удирдлагыг шилжүүлэх журамтай байна.

(d) Энэ зүйлийн (c) хэсэгт заасан журам нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) удирдлага шилжүүлэлтийг гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтлах:
 - (i) НХУ-ний зэргэлдээх салбартай урьдчилан зөвшилцсөн ба НХУ-ний гэрээнд тусгагдсаны дагуу явагдах;
 - (ii) НХУ-ын нэг салбарын тусгаар ажлын байрууд хооронд гүйцэтгэгдэх ба удирдлага шилжүүлэх зарчим нь тухайн салбар, нэгжийн үйл ажиллагааны зааварт тодорхой тусгагдсан байх.
- (2) дор дурдсан нөхцөлд НХУ-ын нэг салбараас нөгөөд агаарын хөлгийн удирдлага шилжүүлэхийг хориглоно:
 - (i) нислэгийн төлөвлөгөөг бүхэлд нь буюу түүний шаардлагатай хэсгийг урьдчилан дамжуулж мэдэгдээгүй;
 - (ii) НХУ-ын өгөгдсөн зөвшөөрөл, захирамж гэх мэт шаардлагатай хавсралт мэдээлэлгүй;
 - (iii) удирдлага хүлээн авч буй талын зөвшөөрөлгүй үед.

172.8. Хөдөлгөөний эрэмбэ

- (a) НХУ эрхлэхээр өргөдөл гаргагч нь нисэхийн аюулгүй ажиллагааг алдагдуулахгүй байх аргахэмжээг авсан байна. НХУ-ын нэгж нь удирдлага, үйлчилгээгээр хангагдах дор дурдсан давуу эрх олгох журамтай байна:
 - (1) аюулд орсон ба аюул тулгарсан агаарын хөлөг бусад агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
 - (2) буултын эцсийн үе шатуудад яваа болон буулт үйлдэж байгаа агаарын хөлөг хөөрөлт үйлдэх агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
 - (3) буулт, хөөрөлт үйлдэх агаарын хөлөг, явгалж байгаа агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
- (b) Өргөдөл гаргагч нь дараах нислэгүүдэд үйлчлэх тусгай журамтай байна:
 - (1) эмнэлгийн яаралтай тусламж болон хүмүүнлэгийн тусламжийн тусгай үүргийн нислэг;
 - (2) эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны тусгай үүргийн нислэг;
 - (3) иргэний хамгаалалтын ба цагдаагийн шуурхай ажиллагааны тусгай үүргийн нислэг;
 - (4) Монгол Улсын болон гадаад улсын төр засгийн тэргүүн, дээд хэмжээний зочин төлөөлөгчдөд үйлчлэх зорилгоор үйлдэж буй онцгой болон тусгай үүргийн нислэг.
- (c) Өргөдөл гаргагч нь нислэгийн үндсэн цуваагаа хадгалж яваа агаарын хөлөг, уг нислэгийн цувааг эзлэхээр хүсэлт гаргасан агаарын хөлгөөс давуу эрхтэй байх журмыг тогтоосон байна:
 - (1) Агаарын хөлөгт нислэгийн цувааны давуу эрхийг олгохдоо ИКАО-гийн Док 7030, эсхүл НХУ-ний гэрээнд заасан журмыг баримтлах;
 - (2) аюулгүй зайг баримтлах шаардлагын үүднээс тухайн нислэгийн цувааг хадгалан нисч байгаа агаарын хөлөгт нислэгийн өөр цувааг эзлэх заавар өгөгдсөн бол.
- (d) бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь ИНД-71 дүрмийн дагуу тогтоогдсон RNP агаарын зай дахь хөдөлгөөний эрэмбийн журамтай байна.
- (e) (a) ба (b) заалтын дагуу, өргөдөл гаргагч нь сонирхогч талуудтай зөвшилцсөнийг үндэслэн хөөрөлт буултын эрэмбийг тодорхойлох бүдүүвчтэй байж түүнийг хэрэглэдэг байна.

- (f) Өргөдөл гаргагч нь (d) ба (e)-гийн дагуу эрэмбэ тогтоосон бөгөөд холбогдох мэдээллийг гомдол хэрхэн шийдвэрлэх журмын хамт Монгол Улсын НМЭ-т тусгасан байна.
- (g) Өргөдөл гаргагч нь аюулгүй ажиллагааг алдагдуулалгүйгээр, аэродром ашиглагчтай хөдөлгөөний эрэмбийн дараах мэдээллийг харилцан мэдээлсэн байна:
- (1) Аэродромд нисэн ирж байгаа болон нисэн гарч байгаа агаарын хөлгүүд;
 - (2) Аэродромын Хөөрөлт буултын бүс дэх үйл ажиллагаа.
- (h) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн бусад зүйлийн дагуу агаарын хөлгүүдийн эрэмбийг тогтоохоос бусад тохиолдолд түрүүлж ирсэн нь түрүүлж үйлчлүүлэх зарчмыг мөрдөнө.
- (i) Өргөдөл гаргагч нь нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ дараах үйлчилгээнээс дээгүүр эрэмбэтэй байх журамтай байна:
- (1) нөхцөл байдал шаардаж байгаа нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
 - (2) бусад НХУ-ний бус үүргүүд.

172.85. Нислэгийн хөдөлгөөний үрсгал зохицуулалт

- (a) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь НХУ-ний багтаамжийн болон аэродромын хүчин чадлын хязгаарлалтууд бий тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үрсгалт зохицуулалтын журмыг тогтоосон байна.
- (b) Журамд дараах зүйлсийг багтаана:
- (1) Холбогдох аэродромын шаардлага, тухайлбал нислэгт үйлчлэх эрэмбэ;
 - (2) Нөлөөлөл үзүүлж болох агаарын тээвэрлэгч, бусад НХУ-ний байгууллагын хэрэгцээ шаардлага;
 - (3) нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын шаардлага, түүний дотор урьдчилан мэдэгдэх шаардлага, идэвхжүүлэх болон иднвхигүй болгох талаарх мэдээлэл.

172.87. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл

- (a) НХУ эрхлэхээр өргөдөл гаргагч нь НХУ-ын зөвшөөрөл олгох журмыг тогтоосон байна.
- (b) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан журамд дараах зүйлүүдийг тусгана:
- (1) НХУ-ын зөвшөөрөл, заавар нь нисэх баг хүчин төгөлдөр бусад хууль дүрмийг зөрчихөд хүргэхээргүй байх;
 - (2) зөвшөөрөл, зааврыг алдаа мадаггүй, тодорхой, стандарт хэлбэрээр олгох;
 - (3) нисэх баг өгөгдсөн зөвшөөрөл ба зааврыг биелүүлэх боломжгүй тухайгаа илтгэсэн тохиолдолд, хэрэв боломжтой бол зөвшөөрөл, зааварт зохих өөрчлөлтийг оруулж дахин олгох;
 - (4) маршрутын дагуу нисэх зөвшөөрөл нь дараах заавар, мэдээллийг агуулна:

- (i) агаарын хөлгийн нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага;
 - (ii) зөвшөөрөл үйлчлэх хязгаар, цэг;
 - (iii) нислэгийн маршрут;
 - (iv) маршрутын нийт ба түүний хэсэгт хадгалан нисэх нислэгийн цуваа, түүний өөрчлөлт; нисэн гарах, ойртолт үйлдэх тогтоосон бүдүүвч, зөвшөөрлийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа гэх мэт бусад заавар, мэдээлэл;
- (5) тухайн орон нутаг, түүний тодорхой нэг бүсэд үйлдэгдэх нислэгт олгох зөвшөөрөлд энэ хэсгийн (4)-т заасан зүйлүүдийн аль тохирохыг багтаан олгоно.
- (6) Дуунаас хурдан агаарын хөлгийн хувьд НХУ-ын зөвшөөрөл нь:
- (i) Дуунаас хурдлах хурдатгалын үе шатны төгсгөл хүртэл байна;
 - (ii) Дуунаас хурдан нислэгээс дууны хүрээн дэх нислэгт шилжих хурдны бууралтын үеийн тасралтгүй өндөр алдалтыг заана.

172.89. Нислэгийн цуваа

- (a) Доор дурдсанаас бусад тохиолдолд НХУ эрхлэхээр өргөдөл гаргагч нь, Улаанбаатарын нислэгийн мэдээллийн районы хүрээнд ХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд ИНД-91.425, ИХНД-ээр үйлдэх нислэгийн хувьд ИНД-91.313-д заасан нислэгийн цувааг сонгох журмыг тогтоосон байна:
- (1) ХНД ба ИХНД-ийн нислэгүүдэд, тэдгээрийн нислэгийн цувааны харьцаа, нислэгийн чиг шардлагагүй.
 - (2) ИХНД-ээр үйлдэх нислэгт ХНД-ын нислэгийн цуваанд нисэх зөвшөөрөл олгосон;

172.91. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрлөөс гажих

- (a) Өргөдөл гаргагч нь, энэ зүйлийн (b) хэсэгт заасантай холбоотойгоор, нисэх баг дараах зайлшгүй шалтгаанаар НХУ-ын зөвшөөрлөөс гажих тохиолдолд нисэх багийн үйлдэлд хориг үл тавих, аюулгүй ажиллагаанд нийцсэн захирамж өгөх талаар мөрдөх журамтай байна:
- (1) агаарын хөлөг ACAS системийн зөвлөмжийг даган маневр үйлдэх; эсхүл
 - (2) GPWS ба TAWS-ын дохиоллоор үйлдэл хийх, эсхүл
 - (3) цаг агаар, эсхүл ослын нөхцөл байдлын улмаас НХУ-ын зөвшөөрлөөс гажих
- (b) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан журамд, аюулаас зайлах маневр гүйцэтгэсний дараа нислэгийн цуваачлал, зайчлалыг нэн даруй эргүүлэн тогтоохоор тусгана.

172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ

Ерөнхий

- (a) Өргөдөл гаргагч нь, дараах нөхцөлд агаарын хөлгийг нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангахад мөрдөх журмыг тогтоосон байна:
- (1) Бүх агаарын хөлөг НХУ-аар хангагдаж байгаа бөгөөд (b) хэсэгт заасан нислэгийн мэдээллийн үйлчилгээ шаардлагатай.
 - (2) агаарын хөлөг аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангагдаж байгаа ба (b) хэсэгт заасан үйлчлэгээгээр хангагдах шаардлагатай; эсхүл

- (3) агаарын хөлөг ХНД-ээр нислэг үйлдэж байгаа ба нислэгийн мэдээллийн үйлчилгээ шаардлагатай; эсхүл
- (4) агаарын хөлөг ИХНД-ээр нислэг үйлдэх ба НХУ-ний нэгжид ИХНД-нр нисэх нислэгийн төлөвлөгөө бөглөн ирүүлсэн;
- (5) агаарын хөлөг ИХНД-ээр нислэг үйлдэх ба нислэгийн мэдээлэл авахыг хүссэн.
- (b) Өргөдөл гаргагч нь нислэгийн мэдээлэлд нь дараах зүйл багтах журамтай байна:
- (1) SIGMET мэдээ;
 - (2) нисэн гарах, бүүлт үйлдэх ба бэлтгэл аэродромын цаг агаарын бодит ба урьдчилсан мэдээ;
 - (3) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил, галт уулын дэлбэрэлт, галт уулын үнст үүлийн талаарх мэдээлэл
 - (4) агаарт дэгдэн цацагдсан цацраг идэвхит бодис, хорт бодисын талаарх мэдээлэл
 - (5) навигацийн тоног төхөөрөмжийн ажиллагааны горим, ашиглалтын өөрчлөлтийн мэдээ;
 - (6) аэродром, газрын хөдөлгөөний бүс ба түүний орчмын цас, мөс, усны байдал зэргийг багтаасан аэродромын ашиглалтын мэдээ;
 - (7) жолоочгүй агаарын бөмбөлгийн талаарх мэдээлэл
 - (8) нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.
- (c) Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл аэродромын мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Аэродромын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь ХБЗ дээр тогтсон усны байдлыг дараах тодорхойлолтын дагуу өгөх журамтай байна:
- (1) DAMP буюу ЧИЙГТЭЙ – зурвас чийгтэй болсноос өнгө нь өөрчлөгдсөн;
 - (2) WET буюу НОЙТОН – зурвас норсон боловч гадаргууд нь ус тогтоогүй;
 - (3) WATER PATCHES буюу ТОГТООЛ – зурвас дээр хэсэгчлэн тогтсон ус ажиглагдсан;
 - (4) FLOODED буюу YEP – зурвас их хэмжээний үерлэсэн усаар бүрхэгдсэн.

Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл

- (d) НХУ эрхлэхээр өргөдөл гаргагч нь онцгой анхаарах нислэгийн хөдөлгөөний мэдээллийг түүний ойролцоох агаарын хөлгүүдэд мэдээлэх журамтай байна.
- (e) Өргөдөл гаргагч нь, дараах агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний мэдээлэл өгөх журамтай байна:

- (1) “С” ангиллын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт, нисэх баг хүсэлт тавьсан тохиолдолд аюултай ойртолтоос зайлах зөвлөмжийн хамт;
- (2) “D” ангиллын агаарын зайд өдрийн цагт ХНД ба ИХНД-ээр үйлдэгдэж байгаа нислэгүүдэд, нисэх баг хүсэлт тавьсан тохиолдолд аюултай ойртолтоос зайлах зөвлөмжийн хамт;
- (3) “G” ангиллын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдэд нисэх багийн хүсэлтээр.

172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ

(a) Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь аэродромын нислэгийн мэдээллийг дараах хэлбэрээр өгөх журамтай байна:

- (1) хүлээн авсан илтгэл, мэдээлэлд тулгуурлан агаарын хөлгүүд хоорондын байрлалыг харьцуулан тодорхойлох;
- (2) нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дор дурдсан зөвлөмж, мэдээлэл өгөх:
 - (i) аэродром орчмын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (ii) маневрлах талбайд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (iii) буулт, хөөрөлт үйлдэж байгаа агаарын хөлгүүд;
 - (iv) маневрлах талбай дахь агаарын хөлөг, газрын тээврийн хэрэгсэл, хүмүүс;
 - (v) маневрлах талбай дахь агаарын хөлгүүд ба түүн дээрх саадууд.

(b) Өргөдөл гаргагч нь, хөөрөлт буултад ашиглахаар сонгосон ХБЗ нь тухайн төрлийн нислэг, агаарын хөлөгт нийцсэн болохыг бататгах журмыг тогтоосон байна.

172.97. Аюулын дохио, мэдээллийн үйлчилгээ

(a) Энэ дүрэмд агаарын хөлөгт аюул тулгарсан, эсхүл аюулд орсон нөхцөлд дараах агуулгыг илтгэх нэгдсэн нэр томъёог хэрэглэнэ

INSERFA – Тодорхойгүй үе;
 ALERFA – Түгшүүрийн үе;
 DETRESFA – Аюулын үе;
 RCC – Эрэн хайх, авран туслах (цаашид ЭХАТ гэх) зохицуулах төв.

(b) Өргөдөл гаргагч нь, өөрийн хариуцлагын бүсэд дараах агаарын хөлгүүдийг аюулын дохио, мэдээллийн үйлчилгээгээр хангах журам тогтоосон байна:

- (1) аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ явуулж байгаа тохиолдолд аэродромын бүх нислэгийн хөдөлгөөнд;
- (2) дараах бүх агаарын хөлгүүдэд:
 - (i) ИНД-91-ийн 91.307, 91.407-д заасны дагуу нислэгийн төлөвлөгөө ирүүлсэн; ээхүл
 - (ii) Яаралтай нислэгийн хөдөлгөөний үйлчилгээни йтусламж шаардлагатай болохоо илтгэсэн;
 - (iii) хууль бус халдлагад өртсөн өуюу өртсөн байж болзошгүй нөхцөл үүссэн;

(c) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (f) хэсэгт тодорхойлсон аюулын нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх дараах арга хэмжээний журмыг тогтоосон байна:

- (1) энэ зүйлийн (e) хэсэгт заасны дагуу INCERFA, ALERFA, DETRESFA үе шатуудыг зарлах;
 - (2) орон нутгийн авран туслах байгууллагын ажиллагаагаар зохицуулагдахаас бусад тохиолдолд, зарлагдсан аюулын тухай мэдээллийг бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв ба нислэгийн мэдээллийн төвд яаралтай мэдэгдэх.
- (d) Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь нислэгийн онцгой тохиолдол болон онцгой нөхцөлийн үе дэх бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төвийн ажиллагааг зохицуулах дараах журмыг тогтоосон байна:
- (1) UB FIR-ын хүрээнд аюулын нөхцөл байдлын талаархи бүх мэдээллийг цуглуулах үндсэн, төв зангилаа хэлбэрээр ажиллах;
 - (2) энэ зүйлийн (l) хэсгийн (1)-д зааснаас бусад тохиолдолд, цуглуулсан мэдээллийг ЭХАТ зохицуулах төвд яаралтай дамжуулах.
- (e) Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (c) хэсэгт заасанчлан, хариуцлагын бүсэд нь тохиолдсон нислэгийн онцгой тохиолдол ба онцгой нөхцөлийн талаар орон нутгийн авран туслах байгууллагад яаралтай мэдэгдэх журмыг тогтоосон байна.
- (f) Энэ зүйлийн (v) хэсэгт заасан аюулын үе шатуудыг дараах нөхцөлд буюу агаарын хөлөг, түүгээр зорчигчдийн амь нас эрүүл мэндэд ямар нэг эргэлзээ байхгүйгээс бусад тохиолдолд мзарлана:
- (1) INSERFA буюу Тодорхойгүй үе:
 - (i) ХНД, эсхүл хяналттай ИХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгүүд холбоо барих тооцоот цагаасаа хойш 15 минутын хугацаанд радио-холбоо бариагүй, эсхүл агаарын хөлөгтэй холбоо тогтоохоор хийсэн оролдлого үр дүнгүй болсон тохиолдолд аль болох эрт; эсхүл
 - (ii) Нисэх баг нислэгийн төлөвлөгөөгө цуцлаагүй, эсхүл SARTIME зарлаж мэдэгдээгүй, агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох оролдлого үр дүнгүй болсон, эсхүл
 - (iii) нислэгийн төлөвлөгөөнд ИХНД-ээр нислэг үйлдэхээр тусгагдсан ба SARTIME зарлагдаагүй агаарын хөлөг нисэн ирэх тооцоот цагаасаа хойш 30 минутын хугацаанд ирээгүй тохиолдолд; эсхүл
 - (2) ALERFA буюу Түгшүүрийн үеийг (ii), (iii), (iv)-ийн хувьд агаарын хөлөг, түүгээр зорчигчдын амь нас эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн нотолгоо байгаагаас бусад нөхцөлд:
 - (i) агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус халдлагад өртсөн нь тогтоогдсон үед; эсхүл
 - (ii) тодорхойгүй үеийн дараагийн шатанд холбоо алдагдсан агаарын хөлөгтэй боломжтой бүх сувгийг ашиглан холбоо тогтоох нэмэлт арга хэмжээ үр дүнд хүрээгүй буюу уг агаарын хөлгийн талаар ямар нэг мэдээлэл ирээгүй тохиолдолд; эсхүл
 - (iii) тооцоот цагаасаа хойш 5 минутын хугацаанд буулт үйлдээгүй ба дахин холбоо тогтоогоогүй тохиолдолд; эсхүл
 - (iv) агаарын хөлөг ба зорчигчдын аюулгүй байдалд илт аюул тулгарснаас бусад тохиолдолд агаарын хөлөгт ямар нэг эвдрэл, ажиллагааны доголдол гарсан тухай илтгэсэн боловч аргагүйдсэн буулт үйлдэх шаардлага тулгараагүй нөхцөлд.
 - (3) DETRASFA буюу Аюулын үе:
 - (i) түгшүүрийн үеийн дараагийн шатанд радио-холбоо алдагдсан агаарын хөлөгтэй холбоо тогтоох бүх оролдлого амжилтгүй болсон ба агаарын хөлөг аюулд орсон магадлал ихэссэн;

- (ii) тооцоогоор агаарын хөлгийн түлш дууссан буюу аюулгүй буулт үйлдэх хангалттай түлшгүй нь тогтоогдсон;
 - (iii) агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэхээс өөр аргагүй байдалд хүргэх техник тоног төхөөрөмжийн татгалзал, ажиллагааны доголдол тулгарсан тухай мэдээлэл ирсэн;
 - (iv) агаарын хөлөг, зорчигчдод шууд аюул тулгараагүй нь тогтоогдсоноос бусад тохиолдолд агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдсэн нь тогтоогдсон нөхцөлд.
- (g) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (c) хэсгийн (2)-т заасан шаардлагын дагуу аюулын мэдэгдлийг дараах дэс дарааллаар олгох журмыг тогтоосон байна:
- (1) аюулын нөхцөл байдлаас шалтгаалан тодорхойгүй, түгшүүрийн, аюулын үе шатуудыг зарлах;
 - (2) аюулын нөхцөл зарлаж буй салбар, ажилтны нэр буюу дуудлага;
 - (3) аюулын төрөл;
 - (4) нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан чухал мэдээллүүд;
 - (5) хамгийн сүүлд холбоо тогтоосон салбар, нэгжийн дуудлага, холбоо тогтоосон давтамж;
 - (6) агаарын хөлгийн хамгийн сүүлийн байрлал илтгэлт болон байрлалыг хэрхэн тогтоосон тухай тайлбар;
 - (7) агаарын хөлгийн өнгө, таних тэмдэг;
 - (8) мэдээлж буй салбараас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйлдэл.
- (h) Өргөдөл гаргагч нь аюулын мэдэгдлийн дараагийн шатанд ЭХАТ төвийг дараах мэдээллээр шуурхай хангах журмыг тогтоосон байна:
- (1) шаардлагатай нэмэлт мэдээлэл;
 - (2) аюулын нөхцөл байдал төгсгөл болсон тухай мэдэгдэл.
- (i) Өргөдөл гаргагч нь аюулд орсон буюу аюул тулгарсан агаарын хөлөгтэй холбоо барих болон байрлалыг тодорхойлоход шаардлагатай холбоо харилцаа, хяналтын боломжит бүх хэрэгслийг ашиглах журмыг тогтоосон байна.
- (j) Өргөдөл гаргагч нь аюул тулгарсан байж болзошгүй агаарын хөлгийн мэдэгдэж буй хамгийн сүүлийн байрлал нь бүртгэгдсэн, тэмдэглэгдсэн байх журмыг тогтоосон байна.
- (k) Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлага ба нислэгийн мэдээллийн үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:
- (1) бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв ба нислэгийн мэдээллийн төв Тодорхойгүй, эсхүл Түгшүүрийн үеийг зарлаж байгаа тохиолдолд ЭХАТ төвд мэдэгдэхээс өмнө бололцоотой бол тухайн агаарын хөлгийг эзэмшигчтэй харилцаж тодруулга хийсэн байх;
 - (2) бололцоотой бол, ЭХАТ төвд мэдээлсэн бүх мэдээллээр тухайн агаарын хөлгийг эзэмшигчийг хангах.

172.99. Нислэгийн төлөвлөгөө

- (a) Өргөдөл гаргагч нь нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах, түүний дагуу үйлчилгээгээр хангах журмыг тогтоосон байна.
- (b) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a) хэсэгт заасан нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах журамд нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах дараах ерөнхий зарчмыг тусгасан байна:
 - (1) нислэгийн төлөвлөгөө нь зохих маягтын дагуу, шаардлага хангаж байгаа эсэхийг нягтлах
 - (2) нислэгийн төлөвлөгөө нь бүрэн бөглөгдсөн ба шаардлагатай мэдээллийг агуулсан эсэхийг хянах;

(3) нислэгийн төлөвлөгөөг НХҮ-ний байгууллага хүлээн авах ерөнхий шаардлагыг хангасан байх.

(c) Хоёр буюу түүнээс дээш байршлаас НХҮ явуулахаар өргөдөл гаргагч нь ондоо нэгжийн өмнөөс нислэгийн төлөвлөгөө хүлээн авах нэг нэгжийг томилж болно.

(j) НХҮ-ний хүрээнд төвлөрсөн нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт зохицуулалтын үйлчилгээ эрхлэхээр өргөдөл гаргагч нь уг төвлөрсөн нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт зохицуулалтын байр дараах зүйлээр тоноглогдсоныг бататгана:

(1) агаарын тээвэр эрхлэгч болон НХҮ-ний салбараас нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах AFTN, факс, мэдээлэл солилцооны компьютерийн сүлжээ зэрэг харилцаа холбооны хэрэгсэл;

(2) нислэгийн стандарт ба давтагдах төлөвлөгөөг урьдчилан оруулах, идэвхжүүлэх ажиллагаанд зориулагдсан тоноглол.

172.101. Цаг

(a) Өргөдөл гаргагч нь, НХҮ-нд ашиглах цаг хугацааны хэмжүүрт тавигдах дараах шаардлагыг хэрэгжүүлсэн байна:

(1) UTC-гийн 00:00 цагаас тооцоолол нь эхлэн, цаг минут секундын нэгжээр 24 цагийн үечлэлтэйгээр илэрхийлэгдэх Ертөнцийн Үндсэн Цаг (UTC)-ийг хэрэглэх;

(2) UTC цагаас 5 секундээс илүү зөрүүгүй байх, цагийн тохиргоо нь стандарт цаг хугацааны станцын цагтай харьцуулан хийгдэж байх;

(b) Өргөдөл гаргагч нь зөв цагийг мэдээлж, хамгийн ойрхон хагас минутад тохируулга хийх дараах журмыг тогтоосон байна:

(1) аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээний салбарын хувьд өөр эх сурвалжаас тохируулга хийгээгүй тохиолдолд ХНД-ээр нисэх агаарын хөлөгт хөөрөлт үйлдэхээр явгалж эхлэхээс өмнө;

(2) тохируулга хийх хүсэлт тавьсан бүх агаарын хөлөгт

172.103. Өндрийн хэрэглэлийн даралтын тохируулга

(a) Өргөдөл гаргагч нь өндрийн хэрэглэлийн даралтын тохируулга хийх дараах журмыг тогтоосон байна:

(1) QNH даралтын тохируулга нь Гектопаскаль нэгжээр, хамгийн ойр бүхэл утгаар илэрхийлэгдэх;

(2) тухайн аэродромын болон бүсийн QNH даралтын тохируулгыг анхлан холбоо тогтоож буй бүх агаарын хөлөг, түүний дотор ATIS мэдээ хүлээн авсан агаарын хөлөгт мэдээлэх;

(3) агаарын хөлгөөс хүсэлт тавьсны дагуу тухайн аэродромын болон бүсийн QNH даралтын тохируулгыг мэдээлэх.

172.105. Радио холбоо ба телефон утсан харилцааны журам

(a) Өргөдөл гаргагч нь харилцаа холбооны дараах журмыг тогтоосон байна:

(1) энэ зүйлийн (b) хэсэгт заасан, радио болон телефон утсан харилцааны стандарт хэллэгийг ашиглах;

- (2) зөвхөн НХУ-тэй холбоотой буюу нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг дамжуулах холбооны дэглэмийг тогтоосон байх;
- (3) доорхиос бусад тохиолдолд холбоо барих журмыг Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын 2 дугаар дэвтэрт заасны дагуу боловсруулсан байх:
- (i) Монгол Улсын бүртгэлтэй агаарын ИНД-91.249-д заасан шаардлагын дагуу дуудлага хэрэглэж байгаа;
 - (ii) Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа нэгж дуудлагадаа радио-холбооны “Мэдээллийн үйлчилгээ” дагаврыг хэрэглэх.
- (b) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a)-гийн шаардлагыг биелүүлэх үүднээс стандарт хэллэг, түүнийг ашиглах нөхцөлүүд нь дараах баримт бичигт нийцэж байгааг бататгана:
- (1) Энэхүү дүрмийн F бүлэг
 - (2) Хавсралт 10
 - (3) ИКАО-гийн Док 4444
 - (4) ИКАО-гийн Док 9432
- (c) Энэ зүйлийн (b) хэсэгт заагдсан баримт бичгүүд өөр хоорондоо зөрчилдвөл энэ хэсэгт заасан дарааллын дагуу тодорхой нэг хэллэгийг сонгоно.

172.107. Бодит ажиглалтын үйлчилгээ

- (a) Өргөдөл гаргагч нь Нислэгийн хөдөлгөөний бодит ажиглалтын систем ашиглан удирдлага, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна:
- (1) Бодит ажиглалтын үйлчилгээг дараах баримт бичгүүдэд заасны дагуу үзүүлэх:
 - (i) ИКАО-гийн Док 4444; эсхүл
 - (ii) ИКАО-гийн Док 7030 (Ойрхи Дорнод/Азийн бүсэд хэрэглэгдэх байдлаар нь; эсхүл
 - (iii) Энэхүү дүрмийн G бүлэг.
 - (2) Хоёрдогч радио-локаторын кодчиллол нь ИКАО-гийн Агаарын навигацийн төлөвлөгөөнд заасан стандартад нийцэж байх;
 - (3) Хоёрдогч радио-локаторын код ашиглах төлөвлөгөө нь дотоодын нислэгт дараах шаардлагыг хангахуйцаар бэлэн байх.
 - (i) ИКАО-гийн Док 4444-т заасан зарчмыг хангаж байх;
 - (ii) ИНД-91 дүрмийн 91.247-гийн (a)-д заасан хүснэгттэй зөрчилдөхгүй байх.
 - (4) дараах бүрэн мэдээллийг нисэх баг, агаарын хөлөг ашиглагчид өгсөн байх:
 - (i) НХУ-ний бодит ажиглалтын үйлчилгээний төрөл, цар хүрээ;
 - (ii) НХУ-ний бодит ажиглалтын үйлчилгээний хязгаарлалтууд.
 - (5) Бодит ажиглалтын үйлчилгээний талаарх мэдээлэл НХУ үзүүлэх ажлын байруудад байршигдсан байна.

172.109. Нислэгийн онцгой нөхцөл ба онцгой тохиолдол

(a) Өргөдөл гаргагч нь аюулд орсон буюу аюул тулгарсан агаарын хөлөгт боломжтой бүх туслалцааг үзүүлэх, давуу эрх олгох журмыг тогтоосон байна.

(b) Өргөдөл гаргагч нь шаардлагатай тохиолдолд төөрсөн, үл танигдах нислэг, улсыг батлан хамгаалах салбарын зэвсэгт хүчинд албадан саатуулагдсан агаарын хөлөгт туслалцаа үзүүлэх журмыг тогтоосон байна.

172.111. Осол сүйрлийн дараах үеийн ажиллагаа

(a) Өргөдөл гаргагч нь, осол сүйрлийн дараа авч хэрэгжүүлэх ажиллагааны талаар дор дурдсан журмыг тогтоосон байна:

(1) осол сүйрэлд навигацийн аливаа тоног төхөөрөмж нөлөөлсөн эсэхийг нягтлан шалгах;

(2) дараах яаралтай арга хэмжээг авах:

(i) тухайн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа болон ашиглахыг завдаж байгаа бусад агаарын хөлөгт анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх;

(ii) тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн бус байгаа талаар ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан байгууллага, мэргэжилтэнд шуурхай мэдэгдэх.

(3) хэвийн ашиглалт нь алдагдсан тухайн тоног төхөөрөмжийн ажиллагааг яаралтай зогсоолгох талаар арга хэмжээ авах;

(4) ИНД-171-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас зөвшөөрөл өгөгдөх хүртэл (1)-д заасан тоног төхөөрөмжийг ХНД-ээр үйлдэгдэх нислэгүүдийн хооронд аюулгүй зай бариулах зорилгоор ашиглахгүй байх.

172.113. Зөрчил

Өргөдөл гаргагч нь зөрчлийг илтгэх, мэдээлэх талаар дараах журмыг тогтоосон байна:

(1) зөрчлийн тухай илтгэл, мэдээлэл ажиллагааг ИНД-12-ын дагуу гүйцэтгэх;

(2) тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаа, ашиглалтын доголдлын талаар ИНД-91 дүрмийн 91.431-ийн дагуу ирүүлсэн мэдээллийг гэрчилгээжсэн Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагад дамжуулах.

172.115. Бичлэг

(a) Өргөдөл гаргагч нь дараах зорилгод ашиглагдах бичлэгийг тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, баримттай танилцах эрх олгох болон устгах журмыг тогтоосон байна:

(1) НХҮ-ний ажиллагааг шалгах;

(2) осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг болох.

(b) (a)-д заасан илтгэл нь дараах зүйлсийн агуулна:

(1) телефон утсан холбооны яриа;

- (2) радио-холбооны яриа ба нэвтрүүлэг;
 - (3) агаар-газрын тоон өгөгдлийн солилцоо;
 - (4) радио-локаторын мэдээлэл;
 - (5) нислэгийн үндсэн ба давтагдах төлөвлөгөө;
 - (6) нислэгийн хөдөлгөөний стрип;
 - (7) ээлжийн хуваарь;
 - (8) ижил хугацаанд Цаг уурын ба Нисэхийн мэдээлэл хангалтын байгууллагад хадгалагддаггүй тохиолдолд, цаг агаарын болон агаарын навигацийн холбогдолтой нисэхийн мэдээ;
 - (9) энэ дүрмийн 172.123-д заасан чанарын дотоод хяналт шалгалт, дүгнэлтийн хуулбар, дүгнэлтэд шалгалт хийсэн тухай дэлгэрэнгүй тайлан, түүний мөрөөр залруулсан ажиллагаа, анхааруулгыг тус тус хавсаргана.
 - (10) дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан, сургалт дадлагад хамрагдсан байх шаардлагатай бүх ажилчдын түүх:
 - (i) хамрагдсан сургалт дадлага тус бүрийн намтар;
 - (ii) мэдлэгээ шалгуулсан тест, үр чадварын үнэлгээ зэрэг сургалтын шалгатуудын дүн.
- (c) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг цахим бичлэгээр баримтжуулах журмыг тогтоосон байна:
- (1) НХУ-ний радио болон телефон үтсан харилцаа;
 - (2) богино долгионы радио-холбооны харилцаа;
 - (3) хоёрдогч ба анхдагч радио-локатор, бодит ажиглалтын бусад системийн өгөгдөл;
 - (4) нислэгийн хөдөлгөөний удирдлагыг шилжүүлэх, хүлээн авах харилцан зохицуулалт хийх тоног төхөөрөмжийн өгөгдөхүүн.
- (d) Энэ зүйлийн (c) хэсэгт заасан цахим бичлэг нь дараах шаардлагуудыг хангасан байна:
- (1) бичлэгийн хугацаа ба UTC цагийн зөрүү 5 секундээс хэтрэхгүй байх, GPS, эсхүл өөр стандарт цагтай харьцуулан тохиргоо хийгдсэн байх;
 - (2) бичлэг нь дуу болон дүрсийг үнэн зөв хуулбарласан байх;
 - (3) (2)-д заасан бичлэгийн ялгааг тодорхойлсон мэдэгдэл.
- (k) (d) хэсгийн (2)-д дурдсан зорилгоор радио-локаторын зураглал, агаарын хөлгийн байрлалын дүрслэлийг хадгалсан байна.
- (l) (d) хэсгийн (2)-т заасан нөхцөл нь энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж эхлэх өдөр ашиглагдаж байсан тоног төхөөрөмжид хамаарна.
- (m) Өргөдөл гаргагч нь (d)-гийн (2)-д зааснаас бусад бичлэгүүд нь мэдээллийг уншиж болохуйц цэвэр ойлгомжтой байх журам тогтолцоог бүрдүүлсэн байна.

(n) Өргөдөл гаргагч нь доорхоос бусад, (b)-д заагдсан бичлэгийг 31 хоногийн хадгалах журамтай байна:

- (1) 2 жилээс доошгүй хугацаагаар хадгалагдах ээлжийн хуваарь
- (2) энэ дүрмийн 172.121 зүйлийн (a) хэсгийн (2) ба (3)-т заагдсан, 2 жил хадгалагдах бичгэн илтгэлүүд
- (3) тухайн ажилтны 2 жил хүртэл хугацаагаар хадгалагдах сургалт дадлагын бүртгэл намтар.

172.117. Ээлжийн ба ажлын байрны бүртгэл

(a) Өргөдөл гаргагчийн ажлын байр бүр ээлжийн бүртгэлтэй, бүртгэл нь ажлын байранд хадгалагддаг, бүртгэлийн хуудсууд нь зөв дэс дарааллаар дугаарлагдсан байна.

(b) Энэ зүйлийн (a) хэсэгт заагдсан бүртгэлийг хөтлөх ажиллагаанд дараах шаардлагыг мөрдөнө:

- (1) ээлжийн бүртгэлийг ээлжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж байгаа ээлжийн ахлагч буюу гүйцэтгэх албан тушаалтан хариуцах;
- (2) ээлжийн хугацаанд ажлын байранд хадгалагдах;
- (3) бүртгэл хийгдсэн хугацаа тэмдэглэгдэх;
- (4) бүртгэлийг дараагийн ээлжинд шилжүүлэхдээ бүртгэлийн үнэн зөвийг магадлан харилцан хүлээлцсэн тэмдэглэл хийж гарын үсэг зурсан байх;
- (5) бүртгэл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:
 - (i) он сар өдөр, цаг хугацааны зөв дараалалтай, тосон бал, эсхүл бэхээр бичих;
 - (ii) баллаж давхардуулаагүй, гаргацтай;
 - (iii) алдаатай бичиглэлийг тэмдэглэл үйлдэн залруулах ба залруулга хийсэн этгээд гарын үсгээ зурсан.
- (6) бүртгэл хөтөлж эхэлсэн ба дууссан хугацааг тэмдэглэсэн байх, цагийн зөрүү байгаа бол түүний шалтгааныг дурдсан байна;
- (7) бүртгэлийн дэвтрийг дууссан өдрөөс нь хойш 3 жилээс багагүй хугацаагаар хадгална.

(c) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a) хэсэгт заагдсан ээлжийн бүртгэлд тусгагдаагүй мэдээллийг бүртгэх ажлын байрны бүртгэлтэй байна.

(d) Ажлын байрны бүртгэлд дараах тэмдэглэлийг хийх журамтай байна:

- (1) дараах шаардлагатай мэдээллүүд агуулагдсан байх:
 - (o) ажлын байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн хугацаа;
 - (ii) тухайн ажлын байрнаас эрхлэн явуулсан үйлчилгээний төрөл;
 - (iv) ажил үйлчилгээ гүцэтгэсэн ажилтан.
- (2) ажлын байрны бүртгэлийг үйлдсэн өдрөөс хойш 31 хоногоос багагүй хугацаагаар хадгална.

172.119. Аюулгүй байдал, хамгаалалт

- (a) Өргөдөл гаргагч нь НХУ-ний аюулгүй байдлын хөтөлбөртэй байна.
- (b) НХУ-ний аюулгүй байдлын хөтөлбөрт аливаа эвдрэл сүйтгэл, саатал, хохирол учрах, улмаар нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгах үүднээс харуул хамгаалалтад тавигдах шаардлага, сургуулилт бэлтгэлжилт, журмуудыг тусгасан байна.
- (c) (b)-д зааснаар үл хязгаарлан, Аюулгүй байдлын хөтөлбөрт дараах зүйлийг тусгана:
- (1) НХУ-ний салбар, ажлын байранд зөвхөн эрх олгогдсон этгээд нэвтрэх;
 - (2) ээлжинд ажиллаж байгаа ажилтныг гэмт халдлагаас хамгаалах зохицуулалт;
 - (3) тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, хөндлөнгийн хууль бус халдлага хийх оролдлогын үед хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, горим;
 - (4) НХУ-ний салбарт хууль бусаар нэвтрэх, үйл ажиллагаанд нь саад хийх үйлдлийг илрүүлэх зорилгоор тогтмол хяналт тавих.

172.121. Үйлчилгээний саатал

- (a) Өргөдөл гаргагч нь ИНД-12 дүрэмд нэмэлт болгон дараах журмыг тогтоосон байна:
- (1) нисэхийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй НХУ-ний урьдчилан төлөвлөсөн аливаа саатал, түр зогсолтын талаар ИНЕГ-ын даргад мэдэгдэх;
 - (2) урьдчилан төлөвлөгдөөгүй гэнэтийн саатал, түр зогсолтыг шалгах, шалтгааныг тогтоох;
 - (3) урьдчилан төлөвлөгдөөгүй гэнэтийн саатал, түр зогсолтын үеийн нөхцөл байдал, түүнээс шалтгаалан нисэхийн аюулгүй ажиллагаанд тулгарах сөрөг нөлөөллийн талаар ИНЕГ-ын даргад 48 цагийн дотор мэдээлэх.
- (b) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан саатал, түр зогсолтод дараах зүйл багтана:
- (1) үйл ажиллагааг эхлэх хуваарьт хугацаанаас хойш 15 минутаас дээш хугацаагаар үйл ажиллагааг эхлүүлэх боломжгүй болох;
 - (2) НХУ-ний хэвийн ажиллагаанд 10 минутаас дээш хугацаагаар гэнэтийн саатал гарах;
 - (3) үйл ажиллагааг дуусгах хуваарьт хугацаанаас 30 минут, түүнээс дээш хугацааны өмнө үйл ажиллагааг зогсоох.

172.123. Чанарын дотоод хяналт

- (a) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн шаардлагын биелэлтийг бататгах, түүнд хяналт тавих зорилгоор Чанарын дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.
- (b) Чанарын дотоод хяналтын тогтолцоо нь дараах зүйлийг агуулна:
- (1) аюулгүй ажиллагааны бодлого, аюулгүй ажиллагааны журам;

- (2) радио болон телефон утсан холбооны бичлэг, зөрчил доголдлын мэдээлэл, ажилтан ба үйлчлүүлэгчийн мэдээллийг хавсаргасан чанарын үзүүлэлтүүдэд үндэслэн үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал буюу дутагдал гарах шалтгааныг тогтоох журам;
 - (3) илэрсэн дутагдлыг залруулах журам;
 - (4) дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх журам;
 - (5) дотоод аудит үзлэгийн хөтөлбөр;
 - (6) энэ дүрмийн шаардлагын хэрэгжилтийн байдалд удирдлагын зүгээс хэрэгжүүлэх хяналтын журам.
- (c) Аюулгүй ажиллагааны бодлого, журам нь байгууллагын бүх шатанд ойлгомжтой, тодорхой, хэрэгждэг бөгөөд хадгалагддаг байна.
- (d) Залруулах үйл ажиллагааны журамд дараах зүйлс тусгагдсан байна:
- (1) дутагдлыг хэрхэн засаж залруулах;
 - (2) авсан арга хэмжээ нь ямар үр дүнд хүрэх;
 - (3) залруулах арга хэмжээний үр дүнд, энэ дүрмээр шаардсан журмуудад шаардлагатай нэмэлтүүдийг хэрхэн оруулах
 - (4) авсан арга хэмжээний үр дүнг удирдлагаас хэрхэн үнэлэх.
- (e) Сэргийлэх үйл ажиллагааны журамд дараах зүйлийг тусгана:
- (1) тулгарсан нөхцөл байдлыг хэрхэн залруулах;
 - (2) авсан арга хэмжээ нь ямар үр дүнд хүрэх;
 - (3) шаардлагатай нэмэлт журмуудыг хэрхэн боловсруулах болон нэмэлт өөрчлөлтийг хэрхэн оруулах;
 - (4) авсан арга хэмжээний үр дүнг удирдлагаас хэрхэн үнэлэх.
- (f) Чанарын дотоод хяналтын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:
- (1) үзлэг хийх давтамж ба салбар, нэгжийг заасан байх;
 - (2) үзлэгт хамрагдах салбар, нэгжид шууд харьяалагддаггүй ажилтан үзлэгийг гүйцэтгэж байх;
 - (3) үзлэгийн тайланг үзлэг хийгдсэн салбарын удирдах болон дотоод хяналт хариуцсан албан тушаалтан, ажилтанд илтгэх;
 - (4) үзлэгээр илрүүлсэн зөрчил дутагдлыг залруулах, давтагдахаас урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах ба авах арга хэмжээг тодорхойлон мэдэгдэх;
 - (5) үзлэгийн дараа авч хэрэгжүүлсэн залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих.
- (g) Удирдлагын хяналтын журамд дараах зүйлс тусгагдсан байна:
- (1) тогтолцооны үр дүнтэй үйл ажиллагааг бататгах зорилготой чанарын дотоод хяналтад хийх удирдлагын үзлэг шалгалтын давтамж
 - (2) чанарын дотоод хяналтад хяналт тавих албан тушаалтан
 - (3) үзлэгийн үр дүнг үнэлж бэртгэдэг байх.

(h) Чанарын дотоод хяналт хариуцсан ажилтан нь байгууллагын удирдлагуудтай аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын асуудлаар шууд харьцах эрхтэй байна.

172.125. Байгууллагын үйл ажиллагааны зааварт тавигдах шаардлага

(a) Өргөдөл гаргагч нь дараах мэдээллийг агуулсан Үйл ажиллагааны заавартай байх ба түүний хүчин төгөлдөр хувийг гэрчилгээжих өргөдлийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- (1) байгууллагын журам, зааврыг энэ дүрмийн шаардлагын дагуу боловсруулан албажуулсан бөгөөд түүнийг бүрэн хэрэгжүүлж, байгууллагын бүх ажилтнууд дагаж мөрддөг тухай тухайн байгууллагын удирдлагаас бичгээр гаргасан баталгаа;
- (2) энэ дүрмийн 172.51 зүйлийн (a) хэсгийн (1), (2)-т заасан удирдах ба гүйцэтгэх албан тушаалтнуудын нэрс, албан тушаал;
- (3) (a) хэсгийн (2)-т заасан гүйцэтгэх албан тушаалтнууд, ажилтнуудын албан тушаал/ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь, байгууллагыг төлөөлөх эрх, ИНЕГ- даргатай харилцах чиглэл;
- (4) энэ зүйлийн (a) хэсгийн (2)-т заасан гүйцэтгэх албан тушаалтнуудын харилцан ажиллах дэг горимыг энэ зүйлийн (a) хэсгийн (5)-ын (i)д заасан салбар, нэгж, бүрээр харуулсан бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч;
- (5) нэгээс дээш нэгжээс НХУ эрхэлж буй тохиолдолд дараах мэдээллийг агуулсан хүснэгт:
 - (i) НХУ-ний нэгжүүдийн байршил, нэр;
 - (ii) хариуцах агаарын зай, аэродром;
 - (iii) эрхлэх үйлчилгээ.
- (6) өргөдөл гаргагчийн салбар, нэгж тус бүрийн орон тоо, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн хангалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) үйл ажиллагааны горим, ажилтнуудын мэргэжлийн төвшин, бэлтгэл нь энэ дүрмийн 172.51 зүйлийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон мэдээлэл;
- (8) НХУ-ний мэргэжилтэн, ажилтнуудын сургалт, дадлага нь энэ дүрмийн 172.53 зүйлийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг бататгасан мэдээлэл;
- (9) (нөөц)
- (10) НХУ-нд ашиглагдаж байгаа дэлгэцийн систем нь энэ дүрмийн 172.57 зүйлийн (b) хэсгийн (5)-ын (i) ба 172.57 зүйлийн (c) хэсгийн (2)-ын (i)-д заагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг бататгасан мэдээлэл;
- (11) энэ дүрмийн 172.59 зүйлд заасан үйл ажиллагааны цагийн хуваарь, үйлчилгээний төрөл;
- (12) энэ дүрмийн 172.61 зүйлд заасан, ээлж хүлээлцэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл, журам;
- (13) энэ дүрмийн 172.63 зүйлд заасан бичиг баримтын бүрдэлтийн баталгаа, хяналт ашиглалтын бүдүүвч;
- (14) энэ дүрмийн 172.65 зүйлд заасан нөөц төлөвлөгөө;
- (15) энэ дүрмийн 172.67-д заасан харилцан ажиллагааны зохицуулалтын журам;
- (16) энэ дүрмийн 172.69-д заасан тоног төхөөрөмжийн ажиллагааны горим, ашиглалтын байдлыг мэдээлэх журам;
- (17) энэ дүрмийн 172.71-д заасан нислэгийн ерөнхий мэдээллийн журам;
- (18) энэ дүрмийн 172.73-д заасан цаг агаарын мэдээ дамжуулах журам;
- (19) энэ дүрмийн 172.75-д заасан бүсийн болон ойртолтын НХУ-ын журам;
- (20) энэ дүрмийн 172.77-д заасан аэродромын НХУ-ын журам;
- (21) энэ дүрмийн 172.79-д заасан хяналттай нислэгийг идэвхитэй тусгай зориулалтын агаарын зайгаас зайчлах журам;
- (22) энэ дүрмийн 172.81-д заасан НХУ-ын хариуцлагын журам;
- (23) энэ дүрмийн 83-д заасан хөдөлгөөний эрэмбэ, давуу эрх олгох журам;
- (24) энэ дүрмийн 172.85-д заасан нислэгийн хөдөлгөөний үрсгалын төлөвлөлт хяналтын журам
- (25) энэ дүрмийн 172.87-д заасан НХУ-ын зөвшөөрлийн журам;

- (26)энэ дүрмийн 172.89-д заасан Нислэгийн цуваачлалын журам;
- (27)энэ дүрмийн 172.91-д заасан НХУ-ын зөвшөөрлөөс гажих журам;
- (28)энэ дүрмийн 172.93-д заасан нислэгийн мэдээллийн үйлчилгээний журам;
- (29)энэ дүрмийн 172.95-д заасан аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний журам;
- (30)энэ дүрмийн 172.97-д заасан аюулын дохио, мэдээллийн үйлчилгээний журам;
- (31)энэ дүрмийн 172.99-д заасан нислэгийн төлөвлөгөө хүлээн авах, дамжуулах журам;
- (32)энэ дүрмийн 172.101-д заасан цаг, хугацааны нэгжийн журам;
- (33)энэ дүрмийн 172.103-д заасан нислэгийн өндрийн тохируулгын журам;
- (34)энэ дүрмийн 172.105-д заасан радио-холбооны журам;
- (35)энэ дүрмийн 172.107-д заасан бодит ажиглалтын үйлчилгээний журам;
- (36)энэ дүрмийн 172.109-д заасан нислэгийн онцгой тохиолдол, онцгой нөхцөлийн үеийн ажиллагааны журам;
- (37)энэ дүрмийн 172.111-д заасан нислэг-техникийн осол, зөрчлийн дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний журам;
- (38)энэ дүрмийн 172.113-д заасан зөрчлийн журам;
- (39)энэ дүрмийн 172.115-д заасан баримтжуулалт, бичлэгийн журам;
- (40)энэ дүрмийн 172.117-д заасан нислэгийн хөдөлгөөн, ээлжийн бүртгэл, ажлын байрны бүртгэлийн журам.
- (41)энэ дүрмийн 172.119-д заасан Аюулгүй байдлын арга хэмжээний хөтөлбөр, түүнд холбогдох журам, заавар
- (42)энэ дүрмийн 172.121-д заасан үйл ажиллагааны саатлын үеийн журам;
- (43)энэ дүрмийн 172.123-д заасан байгууллагын чанарын дотоод хяналтын журам, хөтөлбөр, төлөвлөгөө;
- (44)үйл ажиллагааны зааврын хяналт, өөрчлөлт оруулах журам.

(b) Үйл ажиллагааны заавар нь ИНЕГ-ын даргаар зөвшөөрөгдсөн байна.

С БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

172. 151 Тасралтгүй хэрэгжилт

НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үндсэн шаардлагуудыг биелүүлнэ:

- (1) үйл ажиллагааны зааврынхаа хүчин төгөлдөр хувийг шаардлагатай салбар нэгжийн ажлын байранд байнга хадгалах;
- (2) үйл ажиллагааны заавар, эрхлэх үйлчилгээний жагсаалтад тусгагдсан үйлчилгээний заавар журмуудыг мөрдөж ажиллах;
- (3) эрхлэх үйлчилгээний жагсаалтад дурдсан гүйцэтгэх ажилтнуудад тэдний мөрдвөл зохих журам зааврыг хуваарилах;
- (4) байгууллагын хаяг, телефон утас, факсын дугаар зэрэг харилцах хаягт оруулсан өөрчлөлтийн талаар ИНЕГ-т нэн даруй мэдэгдэх.

172.153. Үйл ажиллагааны журам

(a) НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь ажилтнууддаа мөрдүүлэх зорилгоор Үйл ажиллагааны зааварт тусгагдсан салбар түс бүрийн үйл ажиллагааны журам, үйл ажиллагааны зааврын бүрдэлтэй байна.

(b) Нэг буюу түүнээс дээш байршлаас, НХУ-ний нэгээс дээш төрлийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн салбар, нэгж бүрийн онцлогийг харгалзан үйл ажиллагааны журамдаа нэмэлт тодотгол, зааврыг хавсаргаж болно.

172.155. Түршилтын зөвшөөрөл

(a) НХУБ-ын гэрчилгээ эзэмшигчээс нисэхийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгоор гаргасан хүсэлтийг үндэслэн ИНЕГ нь, дараах түршилтыг гүйцэтгэх зөвшөөрлийг олгож болно:

- 1/ бодит ажиглалтын системийн ашиглалтын түршилт;
- 2/ нислэгийн шинэ хэвшмэл үг хэллэгийг хэрэглэх түршилт;
- 3/ зайчлалын түршилт.

(b) Түршилт нь нэг удаа, 3 сараас дээшгүй байхаар ИНЕГ-ын даргаас зөвшөөрөл олгодсон байх ба НХУБ-ын гэрчилгээ эзэмшигчээс хугацааг сунгах хүсэлтийг бичгээр гаргасан тохиолдолд ИНЕГ-ын дарга зөвшөөрлийг дахин нэг удаа, 3 сарын хугацаагаар сунгаж болно.

(c) ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл түршилтыг хугацаанаас нь өмнө хэзээ ч зогсоож болно.

172.157. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл олгохоос татгалзах

(a) Аэродромын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх эрх бүхий НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дор дурдсанаас бусад тохиолдолд үйлчилгээний төлбөрийг хийгээгүй шалтгаанаар агаарын хөлөгт НХУ-ын зөвшөөрөл олгохоос татгалзахыг хориглоно:

- (1) агаарын хөлөг газарт байрлаж байгаа бол;
- (2) зөвшөөрөл нь агаарын хөлөг маневрлах талбайд нэвтрэх зөвшөөрөл бол.

(b) Агаарын хөлөгт, маневрлах талбайд нэвтрэх зөвшөөрөл нэгэнт олгодсон тохиолдолд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор уг агаарын хөлгийг НХУ-гээр хангана.

172.159. Ил харааны нислэгийг хориглох

Аэродромын ба ойртолтын НХУ эрхэлж буй НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл аэродромын болон ойртолтын НХУ-ын бүсэд ИХНД-ээр нислэг үйлдэхийг хориглох эрхтэй.

172.161. Гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулалтын өөрчлөлт

(a) НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавар болон эрхлэх үйлчилгээнийхээ жагсаалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж байх үүрэгтэй.

(b) НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, Үйл ажиллагааны заавар болон эрхлэх үйлчилгээнийхээ жагсаалтад өөрчлөлт оруулахдаа дараах шаардлагыг хангасан байна:

- (1) өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлагыг хангаж байх,
- (2) байгууллагын дотоод журмын шаардлагыг хангаж байх.

(c) НХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны журам буюу журмын бүрдэлээс бусад, Үйл ажиллагааны заавартаа оруулах өөрчлөлтийг Үйл ажиллагааны заавартаа оруулахаас өмнө дараах байдлаар ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- (1) өөрчлөлт бүрийн хувийг хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс 15 хоногийн өмнө;
- (2) шуурхай буюу яаралтай оруулах өөрчлөлтийг шууд, гэхдээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэх огнооноос өмнө.
- (d) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө ИНЕГ-ын даргад урьдчилан мэдэгдэж зөвшилцсөн байна:
- (1) байгууллагын гүйцэтгэх захирал;
- (2) удирдах албан тушаалтнуудын бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;
- (3) НХҮ-ний үйл ажиллагаанд, хөрш зэргэлдээх улсын НХҮ-нд нөлөөлөхүйц өөрчлөлт орох.
- (e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийх, эсхүл тэдгээрийг мөрдөх нөхцөлийг ИНЕГ-аас тодорхойлж болно.
- (f) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-аас энэ зүйлийн (e) хэсэгт заасны дагуу тогтоосон нөхцөлийг мөрдөж ажиллах үүрэгтэй.
- (g) Энэ зүйлийн дагуу хийгдэх өөрчлөлтүүдийн улмаас гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар байвал НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь уг гэрчилгээг ИНЕГ-ын даргад нэн даруй өгнө.
- (h) Нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавартаа өөрчлөлт оруулах үүрэгтэй.

172.163. Үйлчилгээг цуцлах ба шилжүүлэх

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоох тухай хүсэлтээ холбогдох тайлбарын хамт үйл ажиллагаагаа зогсоохоор товлосон хугацаанаас 90 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад өгнө.
- (b) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь үйлчилгээний цагийн хуваарийг хорогдуулах хүсэлтээ холбогдох үндэслэлийг тодотгосон тайлбар, шинэ хуваарийн төслийн хамт ИНЕГ-ын даргад өгнө.
- (c) Үйлчилгээний эрхээ өөр этгээдэд шилжүүлж буй НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 172.59-ын (b)-д заасан хариуцлага шилжүүлэх ажиллагаанд саад учруулах, хориг тавихыг хориглоно.

172.165. Аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь түүний байнгын, гэрээт болон түр ажиллуулж байгаа ажиллагсад нь зохих төвшинд аюулгүй ажиллагааны мэдрэг байдал, бэлэн байдлыг хангах үүднээс аюулгүй байдлын хөтөлбөр, журамтай байна.
- (b) Аюулгүй байдлын хөтөлбөр нь дараах зүйлийг агуулна:
- (1) Анхан шатны болон сэргээх сургалт дадлага;
- (2) Явагдсан сургалт дадлагад зориулагдсан мэдлэгийн шалгалт болон чадварын үнэлгээ

(с) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)-гийн (1)-д заасан нөхцөлийг хангах үүднээс дараах журмыг тогтоосон байна:

- (1) Сургалтын хөтөлбөр нь ИНЕГ-ын дарга зөвшөөрсөн хичээлийн сэдэвтэй байх;
- (2) Сургалт нь гэрчилгээ эзэмшигчийн томилсон ажилтантай харилцан зохицуулалттай, хамтарсан байдлаар явагддаг байх.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д заасан сургалтад хамрагдах ажилтнууд 3-аас ихгүй жилийн хугацаанд хамрагдсан сургалтын сэдвээр сэргээх сургалтад хамрагдах журамтай байна.

D БҮЛЭГ. Бусад нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ

172.201. Ерөнхий зүйл

- (a) Аливаа этгээд нь эрхлэх иргэний нисэхтэй холбоотой үйлчилгээ нь ИНД-1 дүрмийн (7)-д тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд хамаарах эсэх талаар тодорхойлуулах хүсэлтийг тухайн үйлчилгээнийхээ тодорхойлолт, нарийвчилсан мэдээллийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлж болно.
- (b) ИНЕГ-ын дарга нь шаардлагатай гэж үзсэн этгээдтэй зөвлөн, ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчилгээ нь ИНД-1 дүрмийн (7) хэсэгт тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ мөн эсэхийг тодорхойлно.

172.203. Шаардлага

Аливаа этгээд энэ дэд бүлгийн дагуу эрх олгогдсон бөгөөд нисэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхэлэхээс бусад тохиолдолд ИНЕГ-ын даргын энэ дүрмийн 172.201 зүйлийн дагуу тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг үзүүлэхгүй.

172.205. Үйлчлэл

- (a) (7) хэсэгт тодорхойлсон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэхээр гэрчилгээ авах өргөдөл гаргагч нь САА 172/1 маягыг бөглөн дараах мэдээллийг хавсарган ИНЕГ-ын даргад ирүүлнэ:
 - (1) Өргөдөл гаргачийн байгууллагын бүтэц зохион байгуулалт ба ИНЕГ-ын даргын шаардах нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний талаарх мэдээлэл;
 - (2) Хуулиар бататгасан журмаар тогтоосон төлбөрийг төлсөн баримт.

172.207. Гэрчилгээ олгох

- (a) ИНЕГ-ын дарга дараах шаардлагыг хангаж байна гэж үзвэл тодорхойлолтын (7)-д заасан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхлэх нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний гэрчилгээг өргөдөл гаргагчид олгож болно:
 - (1) Өргөдөл гаргагч нь зөв тохирох хүн байх;
 - (2) Гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй ажиллагааны ашиг сонирхолд зөрчилдөхгүй байх.

- (b) ИНЕГ-ын дарга нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах зорилгоор гэрчилгээнд нэмэлт нөхцлийг хавсаргаж болно.

172.209. Үйл ажиллагааны нөхцөл

Энэ дэд бүлгийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь уг гэрчилгээнд хавсарган олгосон нөхцлийн хүрээнд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ эрхэлнэ.

Е БҮЛЭГ. Зайчлалын шаардлага, минимум

172.251. Босоо зайчлал

Хяналттай агаарын зайд босоо зайчлалыг дараах тохиолдолд 500 фут хүртэл багасгаж болно:

- (1) Агарын хөлгүүд дунд буюу хөнгөн ангиллын сүүлний хуйлралын ангилалтай
- (2) Нам нисч байгаа агаарын хөлөг нь ИХНД, эсхүл ИХНОД-ээр 4500 футээс нам өндөрт нисч байгаа.

172.253. Ил харааны хосломол зайчлал

Аэродромын нислэгийн удирдагч дараах агаарын хөлгүүдийн хооронд газарзүйн болон ил харааны хосломол зайчлалыг хангалттай зайчлалыг хадгалах зааврын дагуу өгч болно:

- (1) Агаарын хөлөг аэродромоос 10 далайн милийн зайд байгаа ба нислэгийн удирдагчийн ил харааны хяналтад тогтмол байгаа;
- (2) Агаарын хөлөг нислэгийн удирдагчийн ил харааны хяналтад тогтмол байхгүй хэдий ч түүний байрлал нь радио-локатор, эсхүл нисэх багийн илтгэлээр тодорхойлогдож байгаа.

172.255. Аэродромын бүсээс гаднах ил харааны зайлал

Өдрийн цагт, дараах тохиолдолд ил харааны зайчлал зөвшөөрснөөр босоо зайчлалын минимумыг багасгаж болно:

- (1) Агаарын хөгөөс тусгайлсан хүсэлт ирүүлсэн;
- (2) Агаарын хөлөг тус бүр:
 - (i) Нислэгийн хөдөлгөөний ижил ажлын байрнаас хянагдаж байгаа; эсхүл
 - (ii) Зэргэлдээ ажлын байруудаас хянагдаж байгаа, гэхдээ тус байрнуудын нисдэгийн удирдагч нар харилцан зөвшилцж зөвшөөрсөн.
- (3) Агаарын хөлөг тус бүр цаг агаарын ил харааны нөхцөлд байгаа;
- (4) Агаарын хөлөг тус бүр ил хараагаар бие биенээ харж байгаа бөгөөд ил харааны зайчлалаас татгалзаагүй.
- (5) Дагаж яваа агарын хөлөг нь түрүүлж яваа агаарын хөлгийг харж байгаа бөгөөд түүнээс зайчлан нисэхээ илэрхийлсэн.

172.259. Хугацаат тууш зайчлал

Агаарын хөлгүүд нэг чиглэлд, NDB, эсхүл VOR-оос эсрэг чиглэлд бөгөөд тэдгээрт ирсэнээ илтгэх ёстой үед, дараах тохиолдолд 5 минутын тууш зайчлал хадгалуулж болно:

- (1) Нэг агаарын хөлөг нь өндрөө хадгалан чиг шулуун нислэгт ба нөгөө агаарын хөлөг босоо зайчлал хангахаар өндөр авах буюу алдаж байгаа;
- (2) Түрүүлж яваа агаарын хөлөг NDB, эсхүл VOR-ийг 5-аас багагүй минутын өмнө нисэн өнгөрсөн;
- (3) Удаах агаарын хөлөг нь NDB, эсхүл VOR дээр нисч очоогүй байгаагаа илтгэсэн.

172.259. Зайт тууш зайчлал

(a)

F БҮЛЭГ. Стандарт хэвшмэл хэллэг

172.351. Үйлчлэл

- (a) Энэхүү бүлэгт 172.105-ын шаардлагын дагуу тодорхой нөхцөл байдалд хэрэглэх стандарт хэвшмэл хэллэгийг тодорхойлно.
- (b) Энэхүү бүлэгт хаалтад заасан нь түүнд тохирох үгийг нөхөж оруулахыг, ташуу зураасаар заагласан нь түүний хоёр тал дахийн аль тохирохыг сонгож хэлэгрэлхийг заасан болно.

172.353. Нислэгийн удирдагч/Нисэх багийн хэвшмэл хэллэг

- (a) Маршрут, эсхүл нислэгийн цувааг зөвшөөрөх боломжгүй тохиолдол

Агаарын хөлөгт хүссэн маршрут , эсхүл нислэгийн цувааг зөвшөөрөх боломжгүй тохиолдолд:

"(маршрут/цуваа) *NOT AVAILABLE DUE* (шалтгаан)"

(b) Блок цуваа

- (1) блок өндрийг зөвшөөрөх тохиолдолд:

"*MAINTAINBLOCK* (цуваа) *TO* (цуваа)"

- (2) блок өндрийн цуцлах тохиолдолд:

"*CANCEL BLOCK CLEARANCE...*"

(c) DME өндөр авалт, өндөр алдалт

- (1) DME ашиглан шаталсан өндөр авалтыг зөвшөөрөх үед:

"*CLIMB ABOVE DME STEPS*" эсхүл "*CLIMB ABOVE VORSEC DME STEPS*"

- (2) DME ашиглан шаталсан өндөр алдалтыг зөвшөөрөх үед:

"*DESCEND DME STEPS TO* (цуваа)" эсхүл

"DESCEND VORSEC DME STEPS TO (цуваа)"

(d) Ил хараагаар нисэн гарах

Ил хараагаар нисэн гарахыг зөвшөөрөх тохиолдолд:

"VISUAL DEPARTURE"

(e) **Хүлээх**

Тухайн газарзүйн байршилд нэгээс илүү хүлээх бүс тогтоогдсон тохиолдолд хүлээх зааварчилга өгөхдөө:

"HOLD AT (цэгийн нэр). ENTER THE (тодорхойлогч) HOLDING PATTERN"

(f) Урьдчилсан хүлээх зааварчилга

Монгол Улсын агарын тээвэрлэгчдэд хүлээх бүсэд хүрэхээс нь өмнө цуцлагдах хүлээх кааварчилга өгөхдөө:

"PRECAUTIONARY HOLD "

(g) ХБЗ дээрх үйл ажиллагаа

(1) бүрэн зогсоод үргэлжлүүлэх буултад зөвшөөрөл олгохдоо:

"CLEARED STOP AND GO"

(2) Буултад ашиглах ХБЗ-ыг заахдаа: *"RUNWAY (ХБЗ-ын дугаар) CLEARED TO LAND"*

(3) Шуурхай хөөрөх шаардлагатай бол:

"CLEARED IMMEDIATE TAKE-OFF"

(h) Буугаад хүлээх үйл ажиллагаа

Агаарын хөлөгт буугаад буултын дараах гүйлтээ ХБЗ-ны боломжит уртад гүйцэтгэх боломжгүйгээр хүлээн зогсох талаар заавар өгөхдөө:

"LAND AND HOLD SHORT BY (явгалах зам, эсхүл өөр тусгайлан тогтоосон цэг)"

(i) Ил харааны зайчлал

Агаарын хөлөгт өөр агаарын хөлгөөс ил хараагаар зайчлал хадгалах зааварчилгыг өгөхдөө:

"MAINTAIN VISUAL SEPARATION FROM (агаарын хөлөг) TO/UNTIL (зөвшөөрлийн хязгаар)"

(j) Саадаас зай барих

(1) нисэх багт радио-локатораар саадын өгөгдлийн зураг ашиглан өндөр алдах заавар өгөхдөө дараах дагаварыг ашиглах:

"... RADAR TERRAIN"

(2) агаарын хөлөгт саадаас өөрөө зай барин нисэх зааварчилгыг өгөхдөө:

"MAINTAIN TERRAIN CLEARANCE VISUALLY"

(k) Хууль бус халдлагыг баталгаажуулах

Хоёрдогч радио-локаторын А горимын 7500 кодыг санаатай тохируулсныг баталгаажуулахдаа:

"CONFIRMSQUAWKING 7500"

(l) Нисдэг тэрэгний үйл ажиллагаа

Хяналттай аэродромд, маневрлах талбайгаас гадна нисдэг тэрэгний хөдөлгөөнд зөвшөөрөл олгохдоо:

"LAND/TAKEOFF/AIR TAXI AT YOUR DISCRETION"

(m) Агаарын хөлгөөс зайх заавар

Ондоо агаарын хөлгөөс зайлах зааврыг өгөхдөө:

"SUGGEST"

(n) Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл

ХНД-ийн өөр агаарын хөлгийн мэдээлэлгүй үед:

"NO REPORTED IFR TRAFFIC"

(o) Тойрогт орох заавар

(1) агаарын хөлөгт стандарт тойрогт орох заавар өгөхдөө:

"MAKE STANDARD OVERHEAD JOIN"

(2) агаарын хөлөгт аэродром дээр нисэн өнгөрөөд тодорхой тойрог нислэгт орох заавар өгөхдөө:

"CROSS OVERHEAD, JOIN (тусгай зааварчилга)"

172.355 НХҮ-ний харилцан ажиллагааны хэвшмэл хэллэг

(a) Аэродромын удирдлагын чөлөөлөх зааварчилга

(1) Хязгаарлалт үгүй үед: *"RELEASED"*

(2) Агаарын хөлөг газарт хүлээх шаардлагатай тохиолдолд:

"HOLD"

(3) чөлөөлөх хугацааг заах тохиолдолд:

"CLEARANCE VALID/EXPIRES AT (цаг)"

(4) чөлөөлөх нь хугацааны интервалд суурилж байгаа үед:

"RELEASED (минутын тоо) MINUTES BEHIND (өмнөх агаарын хөлөг)"

(5) чөлөөлөх нь босоо зайчлалын стандартын үйлчлэлд тулгуурлаж байгаа бол:

"RELEASED AFTER (өмнөх агаарын хөлгийн дуудлага) HAS PASSED
(өндөр)"

(6) Чөлөөлөх нь аэродромын удирдлагаас агаарын хөлгүүдийг зайчлахад суурилж байгаа ба RYS
товчлол нь "Released,
your separation" *умгыг илтгэж байгаа бол:*

"RYS (огтлолцох буюу давхцах агаарын хөлгийн дуудлага) (огтлолцох буюу давхцах
хөдөлгөөний талаарх тодорхой мэдээлэл)"

(b) зайчлал хангуулах хариуцлагыг тодотгох

Хэн зайчлал хадгалах талаар мэдээлэх, эсхүл тодотгох бөгөөд энэхүү зохицуулалтыг баталгаажуулах
үед:

"MYSEPARATION/YOUR SEPARATION (огтлолцох/давхцах агаарын хөлгийн дуудлага)"

(c) радар нислэгийн удирдагчдын хоорондох харилцан зохицуулалт

(1) Радар удирдлага шилжүүлэх үед: "RADAR RELEASE (тайлбар)"

(2) Зөвхөн радараар таних мэдээлэл дамжуулах үед:

"RADAR IDENT (тайлбар)"

(d) шинэчилсэн тооцоот цагийн мэдээлэл солилцох

(1) шилжүүлж байгаа нислэгийн удирдагчийн саначилгаар:

"WILL YOU ACCEPT (тайлбар)"

(2) хүлээн авах нислэгийн удирдагчийн татгалзал:

"NEGATIVE, WILL ACCEPT (хэрхэн хүлээн авах талаарх тайлбар)"

G БҮЛЭГ— РАДАР ЖУРАМ

172.401 Хоёрдогч радарын C горимын өндрийн мэдээллийг баталгаажуулах

(a) (b) хэсэгт холбоотойгоор, аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагаас цамхагийн радар
агаарын хөлгийн өндрийг аэродромын төвшнөөс эерэг өндөр авалтыг үзүүлж байгаа тохиолдолд C
горимын өндрийн мэдээллийг баталгаажуулж болно.

(b) Дэлгэц дээрх өндрийн өгөгдөл нь агаарын хөлөг хөөрөхөөр гүйж байх үед аэродромын
төвшнөөс дээш 300 футээс дээш өндрийг үзүүлж байгаа тохиолдолд C горимын мэдээллийг
хэрэглэхгүй.

172.403 Хурдны

Speed control shall not be applied or continued after a point 4 nm from the runway threshold on final
approach.